



**ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР**



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2020 ОНЫ БҮТЭН ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

**ТАЙЛАНГ ХҮЛЭЭН АВАГЧ:
ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ**

**УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГА Д.ДЭЛГЭРСАЙХАН**

2020 ОН

АГУУЛГА

НЭГ.ЕРӨНХИЙ ТОЙМ.....	3
1.1. Хуулийн хэрэгжилтийг хангах, улсын бүртгэлийн үйлчилгээг хялбаршуулж, түргэн шуурхай, боловсронгуй болгох ажлын хүрээнд:	3
ХОЁР. БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА	4
2.1. Иргэний улсын бүртгэл хөтлөх хүрээнд :.....	4
2.1.1. Цахим иргэний үнэмлэхийн бүртгэлийн чиглэлээр:.....	6
2.1.2. Үндэсний энгийн гадаад паспорт болон шилжин суурьших хөдөлгөөний бүртгэлээр	7
2.1.3. Монгол Улсын Их Хурлын болон Аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ-ын ээлжит сонгуулийн ажлын хүрээнд	8
2.2. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх хүрээнд:	10
2.3. Хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх хүрээнд:	11
ГУРАВ. ХЯНАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА	13
3.1. Иргэн, хуулийн этгээдээс улсын бүртгэлийн чиглэлээр ирүүлсэн өргөдөл гомдлыг шийдвэрлэсэн тухай	13
3.2. Иргэн, хуулийн этгээд, эд хөрөнгийн бүртгэл, архивын үйл ажиллагаанд хяналт тавьсан тухай:	15
3.3. Хяналтын улсын байцаагчийн хийсэн шалгалтын хүрээнд:	17
ДӨРӨВ. АРХИВ, АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА	18
4.1. Иргэний бүртгэлийн архивын чиглэлээр:	18
4.2. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архивын чиглэлээр:	20
4.3. Хуулийн этгээдийн архивын чиглэлээр:	22
ТАВ. ХЭЛТСИЙН БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА.....	22
5.1. Мэдээллийн технологи, програм хангамжийн ажлын хүрээнд:	22
5.2. Мэдээллийн аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд:.....	25
5.3. Хүний нөөцийн ажлын хүрээнд:	25
5.4. Санхүү, аж ахуй, хангамж үйлчилгээний ажлын хүрээнд:	26
5.5.Үйл ажиллагааг тайлагнах ажлын хүрээнд:.....	27
5.6. Албан хэрэг хөтлөлт, өргөдөл, гомдол шийдвэрлэх ажлын хүрээнд:	28
5.7. Сургалт, сурталчилгаа, ил тод нээлттэй байдал	30
5.7. Олон нийтийн ажлын хүрээнд.....	38
5.8. Аймгийн төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтын ажиллагаа, уулзалтын талаар	39
5.9. Улсын бүртгэлийн байгууллага үүсэж хөгжсөний 80 жилийн ойн хүрээнд .	41

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

НЭГ.ЕРӨНХИЙ ТОЙМ

Тус хэлтэс нь 2020 онд хууль тогтоомжид заасан улсын бүртгэлийн үйл ажиллагааны үндсэн чиг үүрэг болон бусад чиг үүргийг хэрэгжүүлэх, “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, УБЕГ-ын болон Хэлтсийн 2020 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, улсын бүртгэлийн үйлчилгээг түргэн шуурхай, боловсронгуй болгох, зардал, шат, дамжлагыг багасгах зорилт тавьж ажилласан болно.

Энэхүү зорилтын хүрээнд хуульд заасан бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн хөтлөх, иргэн, хуулийн этгээдэд цахимаар үйлчилгээ үзүүлэх, улсын бүртгэлийн үйлчилгээг хялбаршуулж, түргэн шуурхай болгох зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөн, тайлангийн хугацаанд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

1.1. Хуулийн хэрэгжилтийг хангах, улсын бүртгэлийн үйлчилгээг хялбаршуулж, түргэн шуурхай, боловсронгуй болгох ажлын хүрээнд:

Тус хэлтэс нь улсын бүртгэлийн үйлчилгээг аймгийн нийт иргэд хөдөлмөрчдөд хуулийн хүрээнд хүртээмжтэй, шуурхай хүргэхэд онцгой анхаарал хандуулан ажиллаж байна.

Улсын бүртгэлийн үйлчилгээний шат дамжлагыг багасгах, үйлчилгээний хүртээмжийг нь нэмэгдүүлэх зорилгоор Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл болон хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр гарын авлага болон бусад материалаар хангаж, бүртгэлийн бүрдүүлбэр хангуулсны үндсэн дээр мэдүүлэг хүлээн авах ажиллагаанд улсын бүртгэгчдийг сургасан болно.

Өнөөдрийн байдлаар эд хөрөнгийн эрхийн анхны бүртгэлийг 5 хоногийн дотор, эд хөрөнгө өмчлөх эрх, гэрээ хэлцлийг 3 хоногийн дотор, яаралтай үйлчилгээний хөлс төлсөн барьцааны гэрээг ажлын 4 цагийн дотор тус тус бүртгэж, улсын бүртгэлийн үйлчилгээний шуурхай байдлыг ханган ажиллаж байна.

Дэлхий нийтийг цочроосон COVID-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх үүднээс ажлын горимийг багасган, иргэдэд онлайн /e- barimt, e-mongolia/ үйлчилгээ авах талаар мэдээ мэдээллийг тухай бүр мэдээллийн самбар болон олон нийтийн радио телевиз, мэдээллийн самбарт байршуулан, хэрхэн ажиллах заавар зөвлөмжийг өгч, түргэн шуурхай үйлчилгээ үзүүлж ажиллаа.

Байгууллагыг стандартын шаарлага хангасан хаягтай болгож, ажлын цагийн хуваарь байршуулав.

Албан хаагчдыг ажлын ажлын үнэмлэхтэй болгов.

Мэдээллийн нээлттэй байдлыг хангаж улсын бүртгэгч нарын цонхонд улсын бүртгэгч албан тушаал, нэр, зурагтай мэдээлэл байршуулав.



Үйлчилгээний зааланд хүн хоорондын зай авах, үйлчилгээ үзүүлэх цонхонд амны хаалтаа зүүх, гараа арутгах анхааруулга стикерүүд байршуулсан.




Хэвлэгдэж ирсэн иргэний цахим үнэмлэх, гадаад паспортуудыг эздэд нь утсаар мэдэгдэж үйлчлүүлэгчидтэй эргэх холбоотой ажиллаж байна. 16 нас хүрээгүй хүүхдийн паспорт олгохдоо “Хилээр гарах тохиолдолд төрсний гэрчилгээг хамт авч явах тухай санамж” бичиг хавсаргаж өгч үйлчилж байна.

ХОЁР. БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2.1. Иргэний улсын бүртгэл хөтлөх хүрээнд :

Тайлангийн хугацаанд Улсын бүртгэлийн Ерөнхий хууль, Иргэний бүртгэлийн тухай хууль, Хууль зүй, дотоод хэргийн сайдын А/207 тоот тушаалаар шинээр батлагдсан “Иргэний улсын бүртгэл хөтлөх журам”-уудыг мөрдлөг болгон Иргэний улсын бүртгэлд 2020 оны байдлаар нийт 23492 иргэн хамрагдсанаас:

Төрсний бүртгэл 2638, хүүхэд үрчлүүлсний 133, овог, эцгийн нэр, нэр өөрчилсний 30, эцэг тогтоосны 25, гэрлэсний 724, гэрлэлт дуусгавар болсны 41, гэрлэлт сэргээсний 1, нас барсны 512, нэмэлт өөрчлөлтийн бүртгэлд 572 иргэн, хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр гэрчилгээ дахин олголтыг 218, нөхөн бүртгэлд 259 иргэн тус тус бүртгэгдсэн байна.




Нөхөн бүртгэлийн журмаар хамрагдсан 259 бүртгэлийг задалж үзвэл төрсний 74, үрчлэлтийн 10, гэрлэлтийн 166, нас баралтын 6 иргэн, овог нэр өөрчлөлт 3 иргэн тус тус бүртгэгдсэн байна.

Шүүхийн шийдвэр болон хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр мэдээллийн санд бүртгэлгүй төрөлтийн 6, гэрлэлтийн 18, нас баралтын 3, үрчлэлтийн 4, архивын эх нотлох баримт болон лавлагааг үндэслэн төрөлтийн 68, гэрлэлтийн 148, үрчлэлтийн 6, нас баралтын 3, овог нэр өөрчлөлтийн 3 нийт 259 иргэний мэдээллийг нөхөн бүртгэлийн журмаар бүртгэж маягтуудын “А” талыг УБЕГ-ын Иргэний улсын бүртгэлийн газарт тухай бүр хүргүүлэн мэдээллийн санд тусгуулсан байна.

Төрөлт, гэрлэлтийн гэрчилгээгээ гээгдүүлсэн болон гэмтэсэн, засвар өөрчлөлтийн бүртгэлийн дахин олголтоор 218 иргэнд гэрчилгээ олгов.

Регистрийн дугаар, хүйс зөрүүтэй, шүүхийн шийдвэрээр нас тогтоолгосон, төрсөн, он, сар, өдөр давхцаж олгогдсон, огт бүртгэгдээгүй зэрэг нийт 31 иргэний регистрийн дугаарын бүртгэлийг хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр бүртгэл хийв.

Тайлангийн хугацаанд гадаад иргэний гэр бүлийн бүртгэлд нийт 25 иргэн хамрагдсанаас төрсний 17, гэрлэлтийн 3, гэрлэлт дуусгавар болсны 1, нас баралт 2, үрчлэлтийн 2 иргэн тус тус бүртгэгдсэн байна.



Сумдаас ирүүлсэн иргэний гэр бүл байдлын бүртгэлийн мэдээг хянах явцад нийт 47 зөрчилтэй бүртгэл илэрсэн бөгөөд зөрчилтэй гэх маягтуудыг сум руу буцаан хүргүүлж зөвтгүүлэн мэдээллийн санд тусгуулсан.

Хугацаа хэтэрсэн нийт 139 бүртгэлийн маягтнуудаас төрсний ИУБ-11 маягт 59, нас барсны ИУБ-18 маягт 80 ширхэг бүртгэлийн маягтуудыг хяналтын улсын байцаагчид тухай бүр хянуулж ажилласан болно.

Онлайн бүртгэлийн системд шивж баталгаажуулсан иргэний улсын бүртгэлийн 4935 маягтуудыг үсгийн дарааллаар галиглан ажлын 7 өдрийн дотор дагалдах хуудсын хамт “А” талыг Улсын бүртгэлийн ерөнхий газрын улсын бүртгэлийн нэгдсэн архивын газарт, “Б” талыг тус хэлтсийн иргэний баримтын архивт жагсаалтын хамт тус тус хүргүүлж ажилласан.

2.1.1. Цахим иргэний үнэмлэхийн бүртгэлийн чиглэлээр:

Тайлангийн хугацаанд иргэний цахим үнэмлэх олгох чиглэлээр дараах ажлыг хийлээ. Нэрийн сан болон шинэчилсэн бүртгэлд иргэний ургийн овог, үсгийн алдааны нэмэлт өөрчлөлт, нэрийн толины баталгаажилт, хаягийн өөрчлөлт, ИУБ-31 алдаатай, хурууны хээ давхардсан зөрчлийг арилгуулж ажилласаны үр дүнд шинээр хамрагдсан 1360 иргэний цахим үнэмлэхний зөрчлийг арилгасан байна.

Үндсэн мэдээллийн санд хаяг болон ургийн овог, нэр зөрүүтэй, үсгийн алдаатай 730, хурууны хээ давхардсан 8 иргэн, шинэчилсэн бүртгэлийн алдаатай авсан 84 иргэнд хяналтын улсын байцаагчаар дүгнэлт гаргаж, ургийн овог оруулах, нэрийн толинд нэр баталгаажуулалт 32, хаягийн өөрчлөлтийг зохих журмын дагуу оруулж ажилласны дүнд нийтдээ 5121 иргэний цахим үнэмлэхийг баталгаажуулсан.


УБЕГ-аас 2020 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар хэвлэгдэж ирсэн 5121 иргэний цахим үнэмлэхийг сум сумаар нь ангилан, нэрсийн жагсаалтад авч нэгжийн бүртгэгчдэд хүлээлгэн өгч ажиллав.

Сумдын бүртгэгчдээс ирсэн иргэний үнэмлэхний 591 дахин олголтын материалыг нэмэлтээр оруулан баталгаажуулалт хийсэн болно. Үүнд: иргэний үнэмлэхээ үрэгдүүлсэн 436, хүчинтэй байдлаа алдсан 106, овог нэр сольсон 12, төрсөн он тогтоолгосон 13, хаягийн хөдөлгөөн 13, цахимаар /онлайн/ захиалсан 11 байна.

Тус аймгаас 25 насны 1553, 45 насны 1122 иргэн сунгалтанд хамрагдаж нийтдээ 2679 иргэний цахим үнэмлэх хэвлэгдсэн байна.

2020 оны байдлаар иргэний цахим үнэмлэхний олголтын бүртгэл хийгдсэн 5121 иргэний ИУБ-21 маягтуудыг мэдээллийн санд шивж, цагаан толгойн үсгийн дарааллаар галиглан “А”, “Б” талыг хэлтсийн иргэний бичиг баримтын архивт тухай бүр хүлээлгэн өгч ажилласан.

/хүснэгт 4/



Ургийн овог болон нэрийн санд нэр нь баталгаажуулж, ургийн овог нэрийн санд тусгагдаагүй, эцгийн нэр болон нэр нь нэрийн санд үсгийн алдаатай, мэдээлийн санд хаяг тусгагдаагүй 589 иргэний жагсаалтыг 7 хоног бүр УБЕГ-ын Иргэний улсын бүртгэлийн газарт хүргүүлэн зөрчил арилсаны дараа баталгаажуулсан, иргэдэд олгосон цахим иргэний үнэмлэхний ИУБ-21 маягтуудын шивэлт 100 хувьтай байна.

2.1.2. Үндэсний энгийн гадаад паспорт болон шилжин суурьших хөдөлгөөний бүртгэлээр

Монгол улсын Засгийн газрын 2016 оны 126 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол улсын Үндэсний энгийн гадаад паспорт олгох, эзэмших, хадгалах тухай”, УБЕГазрын даргын 2018 оны А/394 тушаалаар батлагдсан журам, мөн ХЗДХСайдын 2018 оны 11-р сарын 01-ний өдөр баталсан дугаар А/207 “Иргэний улсын бүртгэл хөтлөх” журмыг мөрдлөг болгон ажиллаж байна.

Үндэсний энгийн гадаад паспорт олголтын чиглэлээр 1810 иргэний захиалга хүлээн авч 7 хоног бүр УБЕГазрын Иргэний улсын бүртгэлийн газарт хүргүүлэн, 1800 иргэнд гадаад паспорт шинээр олгосон байна. Гадаад паспортын тэмдэгтийн хураамжинд 9,050,000 /есөн сая тавин мянга / төгрөг төвлөрүүлсэн байна.


Хугацаа буюу хуудас дууссан, хаяж үрэгдүүлсэн, хүчинтэй байдлыг алдагдуулсан зэрэг шалтгаанаар 963 иргэний үндэсний энгийн гадаад паспортыг хүчингүйд тооцуулсан байна.

Үндэсний энгийн гадаад паспортыг биеийн давхцахгүй өгөгдөлийн бүртгэл болох хурууны хээг уншуулан мэдээллийн санд улсын бүртгэгч бүртгэх ажиллагааг амжилттай хэрэгжүүлэн захиалгыг аван үйлчилж байна.

2020 оны 12 дугаар сарын 07-ны өдөр Иргэний улсын бүртгэлийн газраас “Монгол Улсын үндэсний энгийн гадаад паспорт олгох, эзэмших, хадгалах журам”-ын төслийг ирүүлснийг улсын бүртгэгч нарт танилцуулан санал авч хүргүүлсэн болно.

2020 оны эхнээс эхэлж гарсан Ковид-19 цар тахалтай холбоотойгоор гадаад улсад зорчихгүй болсон тул гадаад паспорт авах иргэдийн тоо 3 дахин буурсан үзүүлэлтэй байна.

/хүснэгт 5/



Засгийн газрын 2018 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 332 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол улсын нутаг дэвсгэрт иргэдийн шилжин суурьших

хөдөлгөөнийг бүртгэх мэдээллэх журам"-ыг мөрдлөг болгон ажиллаж байна. Иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийн чиглэлээр нийтдээ 2071 иргэн шилжилт хөдөлгөөний бүртгэлд хамрагдсанаас: аймаг хотоос бүр мөсөн шилжин ирсэн 105 иргэн, аймаг хот доторх шилжилт хөдөлгөөнд 1966 иргэн тус тус хамрагдсан байна.

2.1.3. Монгол Улсын Их Хурлын болон Аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ-ын ээлжит сонгуулийн ажлын хүрээнд

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдөр батлагдаж, мөн оны 12 дугаар сарын 23-ны өдрөөс дагаж мөрдөхөөр тогтсон. Монгол Улсын Их Хурлын ээлжит сонгуулийг хууль тогтоомжид заасан улсын бүртгэлийн байгууллагын хэрэгжүүлэх чиг үүргийн хүрээнд зохион байгуулах, бэлтгэл ажлыг хангах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2020 оны А/05 дугаар тушаалаар байгуулж, хуулийн хэрэгжилтийг хангах үйл ажиллагааны төлөвлөгөө баталж, хэрэгжүүлэн ажилласан.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлд заасны дагуу УБЕГ-ын даргын 2020 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн А/126 тоот тушаалаар “Иргэний засаг захиргааны нэг нэгжээс нөгөө нэгжид шилжин суурьших хөдөлгөөнийг 2020 оны 2 дугаар сарын 01-ний өдрөөс зогсоож, санал авах өдрийн дараах өдөр өдрөөс сэргээнэ” баталсан. Үүний дагуу шилжилт хөдөлгөөний бүртгэлийг Иргэний улсын бүртгэлийн газрын даргын 2020.01.28-ны өдрийн 5/850 тоот чиглэлийн дагуу хуулийн хугацаанд хийж гүйцэтгэсэн тухай бүрт илтгэх хуудас хүргүүлэн ажилласан болно.

Сонгуулийн хэсэг байгуулж, хэсгийн нутаг дэвсгэр, төвийг зарласан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолыг хүлээн авахдаа эх хувийн нягтлан шалгаж авч, Иргэний улсын бүртгэлийн газарт хэсэг оноох, сонгуулийн төвийг зарласан санал авах байрны хэсгийн төвийг шивж оруулах улсын бүртгэгч нарт эрх нээлгэсэн. Сонгуулийн хэсгийн нутаг дэвсгэр, төвийг зарласан тогтоолыг цахим санд оруулах ажлын хүрээнд эрх нээлгэх албан бичгийг дахин хүргүүлэн улсын ахлах бүртгэгч, төвийн 3 бүртгэгч, Өлгий, Сагсай, Бугат сумдын улсын бүртгэгч нарт эрх нээлгүүлж хүчийг зөв хувиарлан санал авах байрны мэдээллийг 2020 оны 3 дугаар сарын 10-ны өдрөөс мэдээллийн санд тусгуулан, 2020 оны 3 дугаар сарын 13-ны өдөр хянаж баталгаажуулалтыг хийж гүйцэтгэсэн болно.

Тус аймаг нийт 13 сум 97 багтай ба УИХ-ын Сонгуулийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу 96 хэсэг, Бугат сумын 5-р баг 100 гаруй сонгогчтой учраас сумын төв буюу 3 дугаар багтай нэгтгэж хэсэг байгуулсан.

УБЕГ-ын даргын 2020 оны А/372 дугаар тушаалаар батлагдсан “Сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, сонгогч шилжих журам”-ыг дагуу сумдын улсын бүртгэгч нарт тухай бүр үүрэг даалгавар, чиглэл өгч ажиллав.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуулийн 2 дугаар тойрог Баян-Өлгий аймгийн 13 сумын 96 хэсгийн нэрийн жагсаалтыг 3 хувь хэвлэх ажлыг 2020 оны 5 дугаар сарын 27-ны өдөр хэлтсийн ажлын байранд зохион байгуулж, хэвлэгдсэн нэрийн жагсаалтыг 2020 оны 5 дугаар сарын 28-ний өдрөөс 2020 оны 5 дугаар сарын 31-ний өдрүүдэд сумдын сонгуулийн хороодод хүргүүлэв.

УИХ-ын сонгуулийн тухай хуулийн 24 дүгээр зүйл заасны дагуу сонгогч шилжих, нас барсан, түр хасав сэргээсэн, нэмэлт өөрчлөлтийн 1240 лавлагааг хуулийн хугацаанд хэвлэж сонгогчийн нэрийн жагсаалтанд тусгасан болно.

Мөн сонгуулийн үеэр 96 хэсэгт ажиллах 108 итгэмжлэгдсэн ажилтаныг томилж ажиллуулав. 2020 оны 6 дугаар сарын 12-13-ны өдрүүдэд УБЕГ-аас ирсэн сургалтын багийнхантай хамтарч иргэний бүртгэлийн итгэмжлэгдсэн ажилтнуудын сургалтыг зохион байгуулж, тус аймгийн сонгуулийн 96 хэсгийн сонгогчдын нэрийн жагсаалтыг 3 хувь хэвлэн сумдын сонгуулийн хороодод аймгийн сонгуулийн хороотой хамтарч тоног төхөөрөмжийн хамт хүргүүлэн, бүх ажлыг хуульд заасан хугацаанд хийж гүйцэтгэсэний үр дүнд УИХ-ын сонгууль амжилттай ажиллав.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай хууль 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр батлагдаж, мөн оны 02 дугаар сарын 14-ний өдрөөс дагаж мөрдөхөөр тогтсон.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын ээлжит сонгуулийн үйл ажиллагааг зохион байгуулах цаг хугацааны хуваарь, сонгуулийн хууль тогтоомжид заасан улсын бүртгэлийн байгууллагын хэрэгжүүлэх чиг үүргийн хүрээнд зохион байгуулах, бэлтгэл ажлыг хангах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын тушаалаар байгуулж, хуулийн хэрэгжилтийг хангах үйл ажиллагааны төлөвлөгөө баталж, хэрэгжүүлэн ажиллав.

Сонгуулийн хэсэг байгуулж, хэсгийн нутаг дэвсгэр, төвийг зарласан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолыг хүлээн авахдаа эх хувийн нягтлан шалгаж авч, Иргэний улсын бүртгэлийн газарт хэсэг оноох, сонгуулийн төвийг зарласан санал авах байрны хэсгийн төвийг шивж оруулах улсын бүртгэгч нарт эрх нээлгэх бичгийн хамт 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн албан бичгээр хүргүүлсэн болно.

Сонгуулийн хэсгийн нутаг дэвсгэр, төвийг зарласан тогтоолыг цахим санд оруулах ажлын хүрээнд эрх нээлгэх албан бичгийг дахин хүргүүлэн улсын ахлах бүртгэгч, төвийн 3 бүртгэгч, Өлгий сумын улсын бүртгэгч нарт эрх нээлгүүлж хүчийг зөв хувиарлан санал авах байрны мэдээллийг 2020 оны 6 дугаар сарын 22-ны өдрөөс мэдээлийн санд тусгуулан, хянаж баталгаажуулалтыг хийж гүйцэтгэсэн болно. Тус аймаг нийт 13 сум 97 багтай ба 97 хэсэг байгуулсан байгаа. 2020 оны ээлжит УИХ-ын сонгуулийн үед түр хасав тэмдэглэгээг сэргээж орсон 241 иргэний нэрийн жагсаалтыг ИУБГ-т хүргүүлэн зөвөтгүүлсэн болно.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасны дагуу Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2020 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн “Иргэний шилжилт хөдөлгөөнийг түр зогсоох тухай” А/1168 дугаар тушаал, Иргэний улсын бүртгэлийн газрын даргын 2020 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 5/7130 тоотой ирүүлсэн чиглэл, Хяналт шалгалтын газрын даргын 2020 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн 8/7215 тоот чиглэлийг үндэслэн хийж гүйцэтгэсэн ажлын илтгэх хуудсыг 2020 оны 8 дугаар сарын 17-ны өдөр хүргүүлсэн.

УБЕГ-ын даргын 2020 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн А/1271 тоот тушаалаар Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь заалтыг үндэслэн сонгуулийн хэсгийн хороодод ажиллах улсын бүртгэлийн байгууллагын

итгэмжлэгдсэн ажилтны орон тооны хязгаарыг баталсан. Тушаалын хавсралтаар тус аймгийн сонгуулийн хорооны 97 хэсэгт улсын бүртгэлийн байгууллагын 98 итгэмжлэгдсэн ажиллахаар заасан. Гэвч Өлгий сумын 3 дугаар хэсгийн сонгогчдын тоо 2498 болсоноор 1 итгэмжлэгдсэн ажилтантайгаар ажилласан болно.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.9 дэх хэсэгт заасны дагуу 2020 оны 9 дүгээр сарын 17-ны өдөр сонгогчдын нэрийн жагсаалтын хуудас түс бүр дээр хэлтсийн даргын тамгаар баталгаажуулалт хийн хэвлэж, гаргасан нэрийн жагсаалтыг цаасан хэлбэрээр 2 хувь үйлдэн, бэлдсэн сонгогчдын нэрийн жагсаалтыг 2020 оны 9 дүгээр сарын 17-20 өдрүүдийн хооронд тус аймгийн сонгуулийн 97 хэсэгт хүргүүлэн ажиллав.


2020 оны 10 дугаар сарын 3-ны өдөр УБЕГ-аас ирсэн сургалтын багийнхантай хамтарч иргэний бүртгэлийн итгэмжлэгдсэн ажилтнуудын сургалтыг зохион байгуулж, тус аймгийн сонгуулийн 97 хэсгийн сонгогчдын нэрийн жагсаалтыг 3 хувь хэвлэн сумдын сонгуулийн хэсгийн хороодод аймгийн сонгуулийн хороотой хамтарч тоног төхөөрөмжийн хамт хүргүүлэн ажиллав.

Бүх ажлыг хуульд заасан хугацаанд хийж гүйцэтгэсэний үр дүнд аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгууль амжилттай болж өнгөрсөн ба санал тэнцсэн 6 хэсэгт нэмэлт санал хуураалт явуулан ажилласан.

2.2. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх хүрээнд:

Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн үйл ажиллагааг хууль журмын дагуу явуулж, 2020 оны тайлангийн хугацаанд үйлчилгээний хураамжийн орлого 87.6 сая төгрөг, үл хөдлөх хөрөнгө өмчлөх эрхээ худалдсанаас оруулсан татварын орлого 105.2 сая төгрөг, улсын тэмдэгтийн хураамж 3.2 төгрөгийг улсын болон орон нутгийн төсөвт оруулсан байна.

Мэдүүлэг, анхны бүртгэл, гэрээ хэлцэл




Нийтдээ 8425 мэдүүлэг хүлээн авч хянан шийдвэрлэснээс газар өмчлөх, улсын бүртгэл 3201, газар эзэмших, ашиглах эрхийн улсын бүртгэл 1170, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх улсын бүртгэл 3604, төрөөс хувьчилсан орон

сууц өмчлөх эрхийн бүртгэл 450 тус тус улсын бүртгэлд бүртгэж эрхийг нь баталгаажуулсан байна.

Тайлангийн хугацаанд нийт 5954 гэрээ хэлцэл бүртгэж баталгаажуулсан бөгөөд худалдах худалдан авах гэрээ 571, бэлэглэх гэрээ 162, гэрээслэл болон өв залгамжлалөөр өмчлөгч өөрчлөгдөх 114, албадан дуудлага худалдаагаар өмчлөгч өөрчлөгдөх 2, барьцааны гэрээ 26158 барьцааны гэрээ дуусгавар болгох 1855 бүртгэл хийж, 635 бүртгэлд нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Үйлчилгээний хураамж, Улсын тэмдэгтийн хураамж, 2%-ийн татвар.



Архивт 2256 хувийн хэргийг шинээр хүлээн авсан ба 6169 хувийн хэрэгт нөхөн бүрдүүлэлт баяжилт хийсэн байна.

Эрхийн улсын бүртгэлийн талаар иргэн, хуулийн этгээдэд 107 лавлагаа, 76 хуулбар гаргаж өгсөн байна.

2.3. Хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх хүрээнд:

2020 онд 72 хязгаарлагдмал хариуцлагатай компани, хоршоо 3, төрийн бус байгууллага 17, улсын төсөвт үйлдвэрийн газар 8, шашны байгууллага 0, үйлдвэрчний эвлэлийн байгууллага 2, хадгаламж зээлийн хоршоо 1, 1 хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газрын гүйцэтгэх удирдлагыг улсын бүртгэлд бүртгэж, улсын бүртгэлийн гэрчилгээ олгосон. Хуулийн этгээдийн нэмэлт өөрчлөлт 144, 156 нэрийн баталгаажуулалт, 134 хуулийн этгээдэд тамга, тэмдэг хийлгэх хяналтын хуудас олгосон ба 26 хуулийн этгээд тамга, тэмдгээ хураалгасан байна. 2020 оны 12-р сарын 15-ны өдрийн байдлаар 156 хуулийн этгээдийн нэрийн хүсэлтийг хүлээн авч мэдээллийн санд шалгаж баталгаажилт хийж ажилласан.

Шинэчилсэн бүртгэлд хамрагдаагүй 24 хуулийн этгээдийн судалгааг гаргаж 2 удаа жагсаалтыг ХЭУБГ-т хүргүүлж, холбогдох бүртгэлд хамрагдаагүй шашны байгууллагуудын эрх бүхий этгээдэд биечлэн уулзах болон утсаар мэдэгдэж ажилласан. Аймгийн ИТХ-аас шашны байгууллагуудад тусгай зөвшөөрөл олгох журам батлагдаж гараагүй байгаа тул бүртгэл хийгдэхгүй хүлээгдэж байгаа болно.

2020 оны шинээр болон нэмэлт, өөрчлөлтийн бүртгэл хийлгэсэн нийт 352 хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн бүртгэлийг хуулийн хүрээнд бүртгэж, цахимжуулсан болно. Орон нутгийн радиогоор иргэн, хуулийн этгээдэд эцсийн өмчлөгчийн бүртгэлийг хуулийн хугацаанд бүртгүүлэх талаар 12 удаа зар явуулж мэдээлж, мөн сумдад зохион байгуулсан “Нээлттэй хаалга”-ны өдөрлөгөөр газар дээр эцсийн өмчлөгчийн бүртгэлийг бүртгэж ажиллав. 8, 10 сард Татварын хэлстийн албан хаагчидтай хамтран холбогдох хуулиудын талаар болон хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн бүртгэлийн асуудлаар харилцан хамтран ажиллахаар мэдээлэл солилцож ажилласан.

Сумдын бүртгэгч нарт 16 удаа хуулийн этгээдийн улсын бүртгэлтэй холбоотой асуултанд утсаар болон биечлэн зөвлөгөө өгч ажиллав. Мөн сумдын бүртгэгч нараас ирсэн бүрдүүлбэрийг хянан шалгаж, дутуу материалыг нь буцаан, тухай бүр чиглэл өгч ажиллав. Шинээр бүртгэгдсэн хуулийн этгээдүүдийг үдэж хавтаст хийн, УБЕГ-ын 2019 оны А/1050 дугаар тушаалын 2 дугаар хавсралтын дагуу архивчид хүлээлгэн өгч, нэмэлт өөрчлөлт оруулсан хуулийн этгээдүүдийн материалыг журмын дагуу дугаарлаж УБЕГ-ын 2019 оны А/1050 дугаар тушаалын 3 дугаар хавсралтын дагуу нэмэгдсэн хуудсуудын тоогоор архивт шилжүүлж ажиллав.


Тайлант хугацаанд нийт 365 хувийн хэргийг татан авч архивт буцаан оруулсан. Хуулийн этгээдийн улсын бүртгэлтэй холбоотой мэдээг сар, улирал бүрээр цаг хугацаанд нь гаргаж өгөв. Тамга, тэмдэг олголтын мэдээг сар болгон гаргаж хүргүүлэн ажиллав. Удирдлагаас өгсөн бусад нэмэлт мэдээ тайлангуудыг хугацаанд нь хүргүүлж ажиллав. ХЭУБТХуулийн дагуу бүрдүүлэх материалын жагсаалтыг байгууллагын самбарт болон ажлын өрөөндөө байнга байрлуулж ажиллаж байна. Зөвлөгөө авахаар ирсэн давхардсан тоогоор 1436 гаруй иргэнд нэг бүрчлэн хуулийн хүрээнд заавар зөвлөгөө өгч, нэрсийн жагсаалтыг он, сар, өдрөөр хөтлөн ажиллав.

УБЕГ-аас зохион байгуулсан “Тамга, тэмдэг ашиглах” чиглэлийн, итгэмжлэгдсэн ажилтнуудад зориулан явуулсан 2 онлайн сургалтанд, ХЭУБГ-аас “Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн бүртгэл хөтлөх, анхаарах асуудал”, “Хуулийн этгээдтэй холбоотой хууль, журмын хэрэгжилт, анхаарах асуудал” зэрэг онлайн сургалтуудад тус тус биечлэн оролцож, өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон, хэрэгжүүлэн ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд 2020 оны 01 сарын 01-нээс өмнө үүсгэн байгуулж үйл ажиллагаа явуулж буй төрийн байгууллага албан газар, улсын төсөвт үйлдвэрийн газраас бусад нийт хуулийн этгээдүүдийн үүсгэн байгуулагч, гүйцэтгэх захирал нарт 2020 оны 12 сарын 31-нээс өмнө “Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг улсын бүртгэлд бүртгүүлэх” талаар орон нутгийн 9-ийн радиогаар өөрийн биеэр ярилцлага өгч, “эцсийн өмчлөгч”-ийн анхан шатны ойлголт өгч ажиллав. Мөн 2020 оны 05 сараас 07 сар хүртэл “Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг улсын бүртгэлд бүртгүүлэх” талаар орон нутгийн “Дербес” телевизээр олон нийтэд зар, мэдээлэл тавьж, эцсийн өмчлөгчийг бүртгүүлэх талаар арга хэмжээ авч ажиллаж байна. Эцсийн өмчлөгч бүртгүүлэх тухай зарыг олон нийтийн радиод, телевизэд удаа дараа тавьж, иргэн, аж ахуйн нэгжүүдийг идэвхтэй хамруулан бүртгэж байна.

Мөн 2020 оны эхний улиралд хэлтсийн вэб сайтанд хуулийн этгээдийн улсын бүртгэлийн нийт бүрдүүлбэрийг шинэчилж, мөн хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн өргөдлийн маягт болон бусад загвар, маягтуудыг шинэчилэх чиглэлээр хэлтсийн мэдээлэл, технологийн ажилтантай хамтарч мэдээ, мэдээллийг шинэчилэн ажиллалаа.

Хуулийн этгээдийн бүртгэлтэй холбоотой иргэн, хуулийн этгээдтэй холбоотой 59 албан тоот хүлээн авч, хариу хүргүүлсэн болно.



ГУРАВ. ХЯНАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 18.7.1, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10.9, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2019 оны А/289 дугаар тушаалаар баталсан Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх журмын 5 дугаар зүйлийн 5.1-т заасныг тус тус үндэслэн Улсын бүртгэлийн ерөнхий хуульд заасан иргэний, эд хөрөнгийн, хуулийн этгээдийн улсын бүртгэлийг хөтлөхдөө холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актын хэрэгжилтэд байнгын хяналт тавьж, улсын бүртгэлийн зөрчил гарахаас урьдчилан сэргийлэн, улсын бүртгэлийн хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан дүрэм, журам зөрчсөн үйлдлийг илрүүлэн түүнийг таслан зогсоох, илэрсэн зөрчлийг арилгуулан Улсын бүртгэлийн хууль тогтоомжийн биелэлтийг хангуулахаар улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийж, иргэн хуулийн этгээдийн гаргасан өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хуулийн дагуу шийдвэрлэж, засвар өөрчлөлт оруулах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох талаар дүгнэлт гаргаж зөрчлийг арилгах талаар холбогдох иргэн, хуулийн этгээд, албан тушаалтанд шаардлага тавьж, хугацаатай үүрэг даалгавар өгч биелэлтийн хангуулж ажиллаж байна.

3.1. Иргэн, хуулийн этгээдээс улсын бүртгэлийн чиглэлээр ирүүлсэн өргөдөл гомдлыг шийдвэрлэсэн тухай

Иргэн, хуулийн этгээдээс гаргасан өргөдөл, санал, гомдлоор 702 улсын бүртгэлд хяналт, шалгалт хийж хуулийн дагуу 161 бүртгэлд дүгнэлт гаргаж, нийт 866 иргэний улсын бүртгэлийн зөрчлийг хууль тогтоомж зөрчсөн зөрчил гаргасныг хянан шийдвэрлэсэн болно.

Иргэний цахим үнэмлэх хүчингүй болгох тухай 540, 62 гадаад паспорт, 304 улсын бүртгэлийн гэрчилгээг тус тус хүчингүй болгосон.

2020 онд төлөвлөгөө, удирдамжын дагуу Иргэний бүртгэлийн тасгийн Улсын бүртгэгч 3, эд хөрөнгийн тасгийн улсын бүртгэгч 4, 12 сумын, 1 тосгоны улсын бүртгэгч нарын бүртгэлийн үйл ажиллагааг төлөвлөгөөт шалгалт 36, гүйцэтгэлийн 31, гэнэтийн болон төлөвлөгөөт бус 97 удаа хянаж шалгасан ба 42 албан шаардлага гаргаж хүргүүлсэн. Эрх бүхий хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн 5, мэдэгдэл 15, акт 61, хүчингүй болсон бүртгэлийн тоо 130 байна.

Иргэний улсын бүртгэлийн нийт 23108 улсын бүртгэлд хяналт тавьсан, 11200 бүртгэлийг шалгаж 307 зөрчил илэрүүлэн, таслан зогсоох, арилгах холбогдох арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлсэн.

Иргэн, хуулийн этгээдээс гаргасан өргөдөл, санал, гомдлоор 702 улсын бүртгэлд хяналт, шалгалт хийж хуулийн дагуу 161 бүртгэлд дүгнэлт гаргаж, нийт 910 иргэний иргэний бүртгэлийн зөрчлийг арилгасан, 201 бүртгэлд тухай бүр шийдвэр гаргаж, 607 иргэний хууль тогтоомж зөрчсөн зөрчил гаргасныг илэрүүлэн зөрчил шалган шийдвэрлэж нийт 13 070 000 төгрөг торгууль ногдуулсан болно.

2020 оны байдлаар нийт 2459 иргэн, хуулийн этгээдийн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хянан шийдвэрлэж хууль журмын дагуу хариу өгсөн байна. Үүнд:

Иргэдээс улсын бүртгэлийн зөрчил арилгуулах болон хяналтын байцаагчийн дүгнэлт гаруулахаар 910 иргэнд холбогдох өргөдөл хүлээн авч 161 дүгнэлт гаргаж, 942 иргэн, хуулийн этгээдэд хууль журмын дагуу хянаж шийдвэр гаргаж, хариу мэдэгдсэн болно. Дүгнэлтийн хувьд: иргэний бүртгэл хүчингүй болгох тухай 37, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хүчингүй болгох тухай 6, хуулийн этгээдийн улсын бүртгэл хүчингүй болгох тухай 1, иргэний улсын бүртгэл хийх тухай 11, иргэний улсын бүртгэлийн зөрчил арилгах тухай 14, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн зөрчил арилгах тухай 15, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн зөрчил арилгах тухай 1, регистрийн дугаар өөрчилж, дахин олгох тухай 18, Регистрийн дугаар хүчингүй болгох тухай 1 буюу 50 иргэн, регистрийн дугаар сэргээх тухай 1, үрчлэлтийн бүртгэл нөхөн бүртгэх тухай 1, гэрлэлтийн бүртгэл нөхөн бүртгэх тухай 4, гадаад паспортын хориг цуцлах тухай 1, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийг цахим санд оруулах тухай 3, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийг цахим бүртгэлд оруулах тухай 4, Тамга, тэмдгийн хяналтын дугаарыг хүчингүйд тооцох, дахин олгох тухай 1, иргэний улсын бүртгэлд нэмэлт өөрчлөлт оруулах тухай 35, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд нэмэлт өөрчлөлт оруулах тухай 11 дүгнэлт гаргаж 942 иргэн, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн зөрчлийг арилгасан болно.

Өргөдөл гаргасан 702 иргэний өргөдөл, гомдол, мэдээллийг хянан шалгаж хариу өгсөн ба бүртгэлийн хууль тогтоомжийн талаар 36 улсын бүртгэгчид зөвлөгөө, зааварчилгаа өгч бүртгэлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлсэн байна.

Хяналтын улсын байцаагчийн хувьд шүүхийн шийдвэрийг үндэслэн бүртгэл хүчингүй болгох, бүртгэл хийлгэх тухай 10 иргэний өргөдлийг шүүхийн шийдвэрийн хамт хүлээн авч хянаад холбогдох газарт хүргүүлэн ажиллаж байна.

Иргэний цахим үнэмлэх хүчингүй болгох тухай 540 цахим иргэний үнэмлэхийг, 62 үндэсний энгийн гадаад паспорт, 304 улсын бүртгэлийн гэрчилгээг тус тус хүчингүй болгох үйлчилгээг иргэдэд үзүүлэн нийт 304 иргэний

өргөдөл хүсэлтийг хуулийн дагуу хянан шийдвэрлэсэн болно.

Хяналтын байцаагчийн үйл ажиллагааны 16 боть материалыг хууль журмын дагуу 250 хуудас бүхий нэгж үүсгээд архивт хүлээлгэн өгөхөөр бэлэн болгосон.

3.2. Иргэн, хуулийн этгээд, эд хөрөнгийн бүртгэл, архивын үйл ажиллагаанд хяналт тавьсан тухай:

Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх журамд заасны дагуу улсын бүртгэлийн алдаа зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх, улсын бүртгэлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор тус хэлтсийн улсын бүртгэгч нарын нийт 23108 хөтөлсөн бүртгэлд, бүртгэлийн хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавьсан байна. Үүнд иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 18646, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр 3531, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр 268, Улсын бүртгэлийн архивын чиглэлээр 663 бүртгэлд түүврчилссэн болон байнгын хяналт тавьсан байна.

ИРГЭНИЙ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР: Иргэний улсын бүртгэлийн төрсний бүртгэл 843, үрчилсний бүртгэл 59, овог, эцгийн нэр, нэр өөрчилсний бүртгэл 12, эцэг тогтоосны бүртгэл 9, гэрлэсний бүртгэл 318, гэрлэлт цуцалсны бүртгэл 29, гэрлэлт сэргээсний бүртгэл 0, нас барсны бүртгэл 241, иргэний шилжих хөдөлгөөний бүртгэл 1597, Иргэний үнэмлэх дахин олгох 667, иргэний бичиг баримт дахин олгох 304 бүртгэлд, иргэний үнэмлэхийн бүртгэл 2010, олгосон лавлагаан 1302, иргэний үнэмлэх олгох 18956 бүртгэлд тус тус хяналт тавьсан болно.

Тайлангийн хугацаанд холимог гэр бүлийн бүртгэлд нийт 22 иргэн хамрагдсанаас төрсний бүртгэлд 15 иргэн, гэрлэсний бүртгэлд 2, үрчлэлт 1, нас барсны бүртгэл 2, эцэг тогтоолт 2 бүртгэлд хяналт тавьсан байна.

Мөн Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2020 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 2/4861 тоо чиглэл, Хяналт шалгалтын газрын 2020 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн №8/409 тоот чиглэлийн дагуу хэлтсийн 13 сум, 1 тосгоны улсын бүртгэгч нарын 2019 оны 12 сарын 10-аас 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр, 2020 оны 01 дүгээр сарын 11-ний өдрөөс 01 дүгээр сарын 23-ны өдөр, 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрөөс 01 дүгээр сарын 31-ний өдрийг хүртэл бүртгэсэн шилжих хөдөлгөөний нийт 1597 бүртгэгдсэн бүртгэлд хоёр удаа эх нотлох баримт, цахим мэдээллийн санд хяналт шалгалт хийсэн болно.

Хэлтсийн 13 сум, 1 тосгоны улсын бүртгэлийн улсын бүртгэгч нар 2019 оны 12 дугаар сарын 10-ны өдрөөс 2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийг хүртэл хийсэн дараах бүртгэлд байнгын хяналт тавьж шалгалт хийхэд Өлгий сумын 365 бүртгэлийн 7, Толбо сумын улсын бүртгэгчийн бүртгэсэн 57 бүртгэлийн 2, Баяннуур сумын улсын бүртгэгчийн бүртгэсэн 21 бүртгэлийн 4, Цэнгэл сумын улсын бүртгэгчийн бүртгэсэн 32 бүртгэлийн 1, Буянт сумын Толбо сумын улсын бүртгэгчийн бүртгэсэн 3 бүртгэлийн 1, Алтанцөгц сумын улсын бүртгэгчийн бүртгэсэн 13 бүртгэлийн 1, Бугат сумын улсын бүртгэгчийн бүртгэсэн 115 бүртгэлийн 2, Булган сумын улсын бүртгэгчийн бүртгэсэн 39 бүртгэлийн 3, Улаанхус сумын улсын бүртгэгчийн бүртгэсэн 5, Алтай сумын улсын бүртгэгчийн бүртгэсэн 26 бүртгэлийн бүртгэлийн 5, Цагааннуур тосгоны улсын бүртгэгчийн

бүртгэсэн 13 бүртгэлийн 3 зөрчилтэй бүртгэлийн зөрчил тус тус илэрсэн болно. Зөрчлийг арилгах зорилгоор холбогдох албан хаагч нарт зөрчил арилгах тухай №06 дугаартай улсын байцаагчийн шаардлагыг хүргүүлж, биелэлтийг хангуулан ажилласан.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хяналт шалгалтын газрын хяналтын улсын байцаагч Д.Чинтулгын 2020 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр ирүүлсэн №10 дугаар шаардлагын биелэлтийг хангах, зөрчлийг арилгах зорилгоор хууль тогтоомж зөрчиж бүртгэсэн 26 иргэний бүртгэлийг хүчингүй болгох тухай дүгнэлт гаргаж хянан шийдвэрлэсэн болно. Бүртгэл хүчингүй болох тухай 431 дүгээр дүгнэлтийг гаргаж Иргэний улсын бүртгэлийн газарт хүргүүлсэн болно.

Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай хууль, холбогдох бусад хууль, тогтоомжийг нэг мөр ойлгон хэрэгжүүлэх, санал авах өдөр сонгогчдын бүртгэлийг нягтлан шалгах хүрээнд 96 хэсгийн сонгогчдын нэрийн жагсаалт хэвлэх, Сонгогчдын нэрийн жагсаалтад өөрчлөлт оруулах тухай 1240 иргэний эх нотлох баримтыг хянаж шалгав. Сонгогчдын нэрийн жагсаалтад өөрчлөлт оруулах тухай 1236 лавлагааг программд шивэх нэмэлт өөрчлөлт оруулах зэрэг 108 итгэмжлэгдсэн ажилтан нарын үйл ажиллагаанд хяналт тавьж ажилласан ба хууль журам зөрчиж гаргасан 4 лавлагааг хүчингүй болгох тухай дүгнэлт тус тус гаргаж ажиллав.

ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР: Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийх журамд заасны дагуу Хуулийн этгээдийн шинээр бүртгэгдсэн 17, Төрийн байгууллага, албан газар, төсөвт үйлдвэрийн газар 5, Нөхөрлөл 2 Хоршоо 3, Төрийн бус байгууллага 17, нэмэлт өөрчлөлтийн бүртгэл 30, нэрийн баталгаажуулалт 50 бүртгэгдсэн бөгөөд нийт 268 бүртгэлд давхардсан тоогоор хяналт тавьсан байна.

ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР: Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн чиглэлээр нийт 3531 бүртгэлд хяналт тавьсан байна. Үүнд:

Эд хөрөнгө өмчлөх, эзэмших, ашиглах, эрхийн 205, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийн бүртгэл 320, газар өмчлөх эрхийн бүртгэл 215, нэмэлт өөрчлөлт оруулах тухай 185 бүртгэлд, 210 лавлагаа, худалдах худалдан авах гэрээ 211, бэлэглэх гэрээ 102, гэрээслэл болон өв залгамжлал 25, барьцаалбартай барьцааны гэрээ 289, барьцаалбаргүй барьцааны гэрээ 209, барьцаалбаргүй барьцааны гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах 115, барьцаалбартай барьцааны гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах 85, барьцааны гэрээ дуусгавар болгох 263, зэрэг бүртгэлд хяналт тавьсан байна.

Эд хөрөнгийн тасгийн Улсын ахлах бүртгэгч 1, улсын бүртгэгч 4, эд хөрөнгийн бүртгэлийн, хуулийн этгээдийн бүртгэлийн 2 архивын архивч бүртгэлийн үйл ажиллагааг төлөвлөгөөт шалгалт 4, гүйцэтгэлийн 4, гэнэтийн болон төлөвлөгөөт бус 11 удаа хийсэн ба 3 бүртгэлийг хүчингүй болгон 4 бүртгэлийн зөрчлийг арилгах, цахим мэдээллийн санд нэмэлт өөрчлөлт оруулах тухай дүгнэлт гаргасан.

УЛСЫН БҮРТГЭЛИЙН АРХИВЫН ЧИГЛЭЛЭЭР: 2020 оны тайлангийн хугацаанд улсын бүртгэлийн архивын чиглэлээр нийт 871 иргэн, эд хөрөнгийн, хуулийн этгээдийн улсын бүртгэлд холбогдох эх нотлох баримт бүртгэлд хяналт

тавьсан байна. Үүнд иргэн, хуулийн этгээдээс гаргасан өргөдөл, санал, гомдол, мэдээллийн мөрөөр 315 улсын бүртгэлийн эх нотлох баримт бүртгэлд, хяналт, шалгалт хийж хууль журмын дагуу 130 бүртгэлд дүгнэлт гаргаж, 143 бүртгэлд тухай бүр шийдвэр гаргаж хариу өгч, 172 иргэний хүсэлтийг хүлээн авч архивт хадгалагдаж буй эх нотлох баримт, бүртгэлийг газар дээр нь хянаж улсын бүртгэгчийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн чиглэл өгч ажилласан байна.

3.3. Хяналтын улсын байцаагчийн хийсэн шалгалтын хүрээнд:

Улсын бүртгэлийн Ерөнхий газраас ирүүлсэн чиглэлийн дагуу бүртгэлийн үйл ажиллагаанд байнга хяналт тавьж ажилласан ба иргэний, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус, гэнэтийн шалгалт хийж илэрсэн зөрчлийг арилгуулах, арга хэмжээ авч, гарч буй зөрчлийн шалтгаан, нөхцөлийг судалж, бүртгэлийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, цаашид таслан зогсоох зорилгоор зөрчил гаргасан улсын бүртгэгч, сумдын улсын бүртгэгч нарт зөрчигдсэн хууль тогтоомж, журмыг тайлбарлан заавар зөвлөгөөг тухай бүр нь өгч, 8 удаа хууль эрх зүйн сургалт зохион байгуулан, бүртгэлийн хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавин ажиллаж байна.

Тус хэлтсийн даргын баталсан 2020 оны хяналтын байцаагчийн үйл ажиллагааны төлөвлөгөө, Хяналтын байцаагчийн үйл ажиллагааны 2020 оны хагас жилийн төлөвлөгөө, Хяналтын байцаагчийн үйл ажиллагааны 2020 оны эхний улиралын төлөвлөгөө, удирдамжын дагуу Иргэний бүртгэлийн тасгийн Улсын ахлах бүртгэгч 1, улсын бүртгэгч 4, Эд хөрөнгийн тасгийн Улсын ахлах бүртгэгч 1, улсын бүртгэгч 4, 12 сум, 1 тосгоны 14 улсын бүртгэгч нарын болон хэлтсийн иргэний баримтын, эд хөрөнгийн бүртгэлийн, хуулийн этгээдийн бүртгэлийн 2 архивын архивч бүртгэлийн үйл ажиллагааг Улсын бүртгэлийн ерөнхий хууль болон бусад эрхийн актад нийцүүлэн хөдөлж байгаа эсэхэд төлөвлөгөөт шалгалт 36, гүйцэтгэлийн 31, гэнэтийн болон төлөвлөгөөт бус 97 удаа хийсэн ба илэрсэн зөрчлийг тухай бүр арилгуулж, гарсан зөрчлийг таслан зогсоож, бүртгэлийн хууль тогтоомж хийсэн хууль бус 43 бүртгэлийг хүчингүй болгон бүртгэлийн зөрчлийг арилгах, Цахим мэдээллийн санд оруулах залруулга хийх тухай 33 дүгнэлт гаргасан.

Бүртгэл хүчингүй болгох, зөрчил арилгах тухай дүгнэлтэд албан үүрэгтээ хайнга хандаж, улсын бүртгэлийн холбогдох хууль тогтоомжийг зөрчиж бүртгэл хөтөлсөн, зөрчил арилгах таслан зогсоох арга хэмжээ аваагүй улсын бүртгэгч Эд хөрөнгийн улсын бүртгэгч Х.Имашхан, Х.Тилеубек, К.Ерке, Хуулийн этгээдийн улсын бүртгэгч Б.Сауле, Булган сумын улсын бүртгэгч М.Монтай, Алтанцөгц сумын улсын бүртгэгч А.Бадамсүрэн, Өлгий сумын улсын бүртгэгч М.Роза, Х.Амангүл, Алтай сумын улсын бүртгэгч Б.Болормаа, Баяннуур сумын улсын бүртгэгч Д.Тойжан, улсын бүртгэгч С.Арман нарт Төрийн албаны тухай хуулийн дагуу арга хэмжээ авах тухай саналаа дурдаж шийдвэрлүүлэхээр Захиргаа, хүний нөөцийн хэлтэст дүгнэлтийн хувийг хүргүүлэн шийдвэр гаргаж ажиллаж байна. Төрийн албаны тухай хуулийн дагуу арга хэмжээ авах тухай нийт 25 саналыг Захиргаа, хүний нөөцийн хэлтэст хүргүүлсэн.

БУСАД АЖИЛ:

Улсын бүртгэлийн багц хуулийг хэрэгжүүлэхэд гарч байгаа хүндрэлтэй

асуудлын талаар, Зөрчлийн тухай хуулийг хэрэгжүүлэхэд гарч байгаа хүндрэлтэй асуудлын талаарх саналыг холбогдох газарт 3 удаа хүргүүлж, цаг үеийн болон хуулийн хэрэгжилтийн талаар хэлэлцүүлэгт оролцож 2 удаа итгэл тавьсан, 1 удаа прокурорын байгууллагын зохион байгуулсан ажлын байран дахь стресс болон сэтгэл зүйн сургалтад хамрагдав.

Улсын бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой журмын төсөлд 2 удаа, зөрчлийн тухай хуульд 1 удаа санал өгсөн болно..

Иргэн хуулийн этгээдэд холбогдох улсын бүртгэлийн талаар хуульд заасан журмын дагуу зөвлөгөө, мэдээлэл өгч ажилласан. Үүнд: Сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1-т заасан Иргэний Засаг захиргааны нэг нэгжээс нөгөө нэгжид шилжин суурьших хөдөлгөөнийг 2020 оны 02 дугаар сарын 01-нээс санал авах өдрийн дараах өдөр хүртэл түр зогсоохтой холбоотой болон иргэний шилжих хөдөлгөөний бүртгэлд гарч буй зөрчлийн талаар орон нутгийн телевизээр 6 удаа Саян тв, Дервес тв мэдээлэл хийсэн болно.

Улсын бүртгэлийн байгууллагын албан хаагчдын тасралтгүй сургалтын нэгдсэн хөтөлбөр, Улсын бүртгэлийн ерөнхий газрын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, сургалт, семинар зохион байгуулах замаар албан хаагчдын мэдлэг чадавхийг дээшлүүлж, мэргэжил арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах зорилтын хүрээнд Улсын бүртгэл, түүнтэй холбоотой бусад үйл ажиллагаанд зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох, илэрсэн зөрчлийг арилгуулах, улсын бүртгэлийн ажилтны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, улсын бүртгэлийн хууль тогтоомжийг сурталчилах, танин мэдүүлэх зорилгоор өнөөдрийн байдлаар улсын бүртгэгч нарт 6 удаа, иргэдэд 6 удаа сургалтыг зохион байгуулсан. 385 нийт албан хаагч, иргэдийг хамруулаад байна.

2020 оны 10 дугаар сарын 03-ны өдөр УБЕГ-ын сургалтын багтай хамтран Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын 2020 оны ээлжит сонгжжлийн үеэр Улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтнаар тус аймгийн сонгуулийн хэсгийн хороодод ажиллах төрийн албан хаагчдад зориулсан эрх зүй, ирц бүртгэлийн программын сургалтыг амжилттай зохион байгуулсан. АНСДИТХ-ын сонгуулийн тухай хуулийн талаар Сургалтын багийн ахлагч, ХАСХ-ийн ахлах мэргэжилтэн Л.Өнөртуяа, Сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, танилцуулах, хүргүүлэх журам, Санал авах өдөр сонгогчийн бүртгэлийг таньж оруулахад анхаарах асуудал сэдвээр ИУБГ-ын улсын бүртгэгч Н.Мөнхжаргал, Сонгуулийн тоног төхөөрөмж, программын танилцуулгыг МТГ-ын ахлах мэргэжилтэн О.Тунгалаг нар сургалт хийсэн. Сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, танилцуулах, хүргүүлэх үйл ажиллагаанд хяналт тавьж ажилласан болно. Буруу гарсан 9 лавлагааг хүчингүй болгож ажиллав.


ДӨРӨВ. АРХИВ, АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

4.1. Иргэний бүртгэлийн архивын чиглэлээр:

Хэлтсийн даргын өгсөн үүрэг даалгаврын хүрээнд архивт байгаа төрөлт, үрчлэлт, овог нэр өөрчлөлт, гэрлэлт, гэрлэлт цуцлалт, нас барсны бүртгэлийн журналуудыг янзалж хаягжилт хийн төрлөөр нь тавьсан ба хувийн хэргийг байршуулсан хайрцгийн хаягийг шинэчилж үсгийн дарааллаар байршуулсан

байна. Хадгалах нэгжийн хугацаа дууссан ИУБ-21, ИУБ-31 маягтуудын дагалдах хуудасуудыг усгалд оруулахаар бэлдсэн байна.

Тайлант хугацаанд нийт 9337 лавлагаа олгосон ба иргэний үнэмлэхийн зурагтай лавлагаа 1771, ХААТР-1 маягтын лавлагаа 47, шинээр гэр бүл болсон иргэдэд гэрлэсэн эсэхийн лавлагаа 760, гэрлэлтийн бүртгэлийн лавлагаа 699, төрөл садангийн лавлагаа 74, нас барсны бүртгэлийн лавлагаа 660, эцэг тогтоосон 11, төрөлтийн лавлагаа 4499, төрөлт бүртгэлгүй тухай лавлагаа 102, үрчлэлтийн лавлагаа 304, оршин суугаа хаягийн тодорхойлолтын лавлагаа 111, овог нэр өөрчлөлтийн лавлагаа 207, гэрлэлт дуусгавар болсон 12, гадаад паспорт анх удаа авсан 1, гадаад паспорт дахин авсан 2, регистрийн дугаар өөрчилсөн 74, регистрийн дугаарын 3 иргэнд тус тус олгосон байна. Мөн хууль хяналтын байгууллагаас ирсэн 475 албан бичгийн дагуу холбогдох лавлагаа мэдээллэлийг хүргүүлсэн болно.



Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын хүрээнд архивт байгаа төрөлт, үрчлэлт, овог нэр өөрчлөлт, гэрлэлт, гэрлэлт цуцлалт, нас барсны бүртгэлийн журналуудыг янзалж хаягжилт хийж төрөлөөр нь тавьсан ба хувийн хэргүүдийн гадна талын шүүгээний хаягийг сольж үсгийн дарааллаар байрлуулсан. Мөн архивт байрлаж байгаа нягтаршуулсан шүүгэнд хувийн хэргийн байршилын жагсаалт байрлуулсан болно. Устгалд оруулахаар 132 ширхэг баримт бичиг гаргасан.

Өмнөх 2014 он хүртэл хөтөлсөн төрөлт, гэрлэлт, нас баралт, үрчлэлтийн журналуудын жагсаалтыг үргэжлүүлэн 2019 он хүртэл хөтөлсөн. Архивын эрсдэлийн төлөвлөгөө болон баримт бичгийг улсын бүртгэгч нараас архивт хүлээж авах хуваарь батлуулан архивын самбарт байршуулсан. 10-р сарын 15-наас эхлээд иргэн хувийн хэрэгт өмнө нь байсан хаягжилтийг сольж, 100% хаягжилт хийж дууссан.





Мөн архивт байрлаж байгаа нягтаршуулсан шүүгэнд хувийн хэргийн байршилын жагсаалт байрлуулсан болно.



Иргэний бүртгэлийн 1951 оноос хойш журналуудын хаягыг шинээр хийж хаягласан.



4.2. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архивын чиглэлээр:

Тайлант жилийн хугацаанд эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн архивт нийт 2590 хувийн хэргийг шинээр архивт хүлээж авч шинээр нээсэн хувийн хэрэг бүртгэх

маягт дэвтэрт бүртгэж улсын бүртгэлийн дугаарын дэс дараалалын дагуу хаяглаж архивт байршуулсан болно.

Үүнд: газар өмчлөлийн анхны бүртгэл 644, газар эзэмших 1156, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн анхны бүртгэл 790, ашиглах эрхийн 4 хувийн хэрэг орсон байна. Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын тушаалаар бүртгэл нь хүчингүй болж хаагдсан 54 хувийн хэрэг байна.

Мөн улсын бүртгэгч нарын өдөр тутам хүлээж авсан нэмэлт өөрчлөлт, худалдах худалдан авах гэрээ, бэлэглэх гэрээ, өв залгамжлах гэрээ, барьцааны гэрээ, лавлагаа, хуулбар г.м нийт 6125 нотлох баримтуудыг архивт хүлээж авч хувийн хэргийн байжилтыг цаг тухайд нь хийж байршуулсан болно.

Өнөөдрийн байдлаар тус хэлтсийн эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн архивт 29075 хувийн хэрэг хадгалагдаж байна. Үүний : 13986 нь газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө, 12369 нь газар өмчлөл, үлдсэн 2770 газар эзэмших эрхийн бүртгэл, 4 нь ашиглах эрхийн бүртгэлийн хувийн хэрэг байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын ББНША Комиссийн гаргасан шийдвэрийн дагуу хугацаа нь дуусаж хүчингүй болсон 11362 баримт бичгийг устгаж акт үйлдэн УБЕГ газарт хүргүүлсэн болно. Мөн устгалд оруулах 8080 хуудас бичиг баримтын судалгааг гаргаж хүргүүлсэн болно. 2020 оны 10 дугаар сараас эхлэн архивын баримт бичгийн хаягжилтыг шинэчлэн стандарт шаардлагад нийцсэн цаасан хайрцагар 21000 гаруй хувийн хэргийн хайрцагийн сольсон байна.

Архивын баримтын өмнөх байдал



Дараах байдал



Мөн архивын баримтын нягтаршуулсан шүүгээ тус бүрд нь байршлын самбар байршуулсан. Байгууллагын архивын эрсдэлийн төлөвлөгөө, албан хаагчдын 2020 оны үйл ажиллагаанд үүсч хөтлөгдсөн баримт бичгийг архивт хүлээн авах хуваарь батлуулсан болно.

4.3. Хуулийн этгээдийн архивын чиглэлээр:

Тайлант жилийн хугацаанд хуулийн этгээдийн бүртгэлийн 96 анхны бүртгэлийн хувийн хэргийг архивт хүлээж авч улсын бүртгэлийн дугаарын дэс дараалалын дагуу байршуулсан болно. Үүнд: ХХК 66, хоршоо 3, УТҮГ 6, НҮТББ17, ҮЭХороо 2, ТБАГ 2, ХЗХоршоо 1, ЗБН 2 хувийн хэргийг тус тус архивт хүлээж авсан байна. Хуулийн этгээдийн улсын бүртгэгчид бүтэн жилийн хугацаанд 31 хувийн хэргийн баяжилтыг хүлээн авч цаг тухайд нь зохих журамын дагуу байршуулсан болно.

Өнөөдрийн байдлаар тус хэлтсийн хуулийн этгээдийн бүртгэлийн архивт нийт 2087 хувийн хэрэг хадгалагдаж байна.

ТАВ. ХЭЛТСИЙН БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА

5.1. Мэдээллийн технологи, програм хангамжийн ажлын хүрээнд:

Хууль зүйн сайдын 2014 оны А/146 тоот тушаалаар баталсан “Цахим мэдээллийн санд мэдээлэл хүлээн авах, хадгалах, түүний аюулгүй байдлыг хангах журам”-ыг мөрдлөг болгож, мэдээллийн технологийн төлөвлөгөө гаргаж, хэлтсийн даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Байгууллагын үйл ажиллагааны зорилго, зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд байгууллагын нийт албан хаагчдын тоног, төхөөрөмжийн хэвийн ажиллагаа, сүлжээний доголдол, мэдээллийн аюулгүй байдал, Иргэний шинэчилсэн бүртгэлийн тоног төхөөрөмжинд шинэчлэл хийх, гарсан гэмтлийг яаралтай засах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэж байна.

Ажлын хэрэглээний компьютерүүдэд цаг тухайд нь үйлчилгээ хийж, техникийн засварын дэвтэр хөтлөн бүртгэж авдаг. Сумын газар нутгийн байршлаас хамааран нэгжийн шинэчлэлт харилцан адилгүй хийгддэг. Програм болон техник хангамжийн суурилуулалт түүний шинэчлэл, тохиргоог тухай бүр хийж байгаа.

Тус хэлтэст нийт 34 компьютер, 32 хэвлэгч төхөөрөмжтэй. Үүнээс хэлтсийн доторх техник хэрэгслүүд хэвийн ажиллагаатай, анхан шатны улсын бүртгэгч нарын иргэний шинэчилсэн бүртгэлийн техник хэрэгслүүдийн ашиглалтын хугацаа дууссан эвдрэл их гарч байна.


Тайлант хугацаанд хэлтсийн албан хаагчдын компьютерт давхардсан тоогоор 53 удаа үйлчилгээ хийсэн бөгөөд 10 компьютерыг форматалж, бүртгэлийн болон хэрэглээний бүх програм хангамжийг суулгаж ажиллаж байна. 48 ширхэг принтерийн хорыг цэнэглэж засвар үйлчилгээ хийсэн. Afis, дахин олголтын гэрчилгээний програм, ePRS1, ePRS2 систем, хуулийн этгээдийн архивын програм, цахим архив програм, иргэний улсын бүртгэлийн туршилтын шинэ систем болон офлайн программын шинэчлэлүүдийг холбогдох улсын бүртгэгч, архивч нарт цаг тухайд нь суулгаж өгсөн. Цахилгааны хэлбэлзлийн улмаас хэлтсийн төвийн эд хөрөнгийн эрхийн 1 улсын бүртгэгчийн болон мэдээллийн технологийн ажилтны DELL маркийн суурин компьютерийн video chip нь шатсан. Дэлүүн сумын Canon 1000D зургийн аппарат USB оролт нь эвдэрсэн ашиглалтын хугацаа нь дууссан, компьютерт орж ирэхгүй байсан тул дүгнэлтийн хамт МТГ-т хүргүүлэн шинээр солиулж авсан болно.

Сүлжээний тоног, төхөөрөмж болон бүртгэгчдийн тоног төхөөрөмжийн бүртгэл тогтмол хөтөлж байгаа ба эвдрэл, гэмтэл гарсан үед бүртгэж авч, завсар үйлчилгээ хийсэн талаар тэмдэглэл хөтөлдөг.

Сүлжээний төхөөрөмж болон хэрэглэгчийн сүлжээний кабелийн үзүүрт тэмдэглэгээ хийгдсэн. Дотоод, гадаад сүлжээний хэвийн ажиллагаатай. Серверийн өрөөнд хөргөлтийн системтэй шинэ Rack байршуулсан. 7 хоногт 1 удаа энгийн цэвэрлэгээ, 14 хоногт 1 удаа чийгтэй цэвэрлэгээ, улиралд 1 удаа их цэвэрлэгээ хийгддэг. Бүртгэлийн сүлжээг дамжуулж буй FortiNet 80c роутерийн адаптер ажиллагаагүй болсныг шинээр сольсон бусад тоног төхөөрөмжүүд хэвийн ажиллаж байна.


Аймгийн төвийн хэлтсийн сүлжээг MobiNet компаниас авдаг байсныг 2020 оны 01-р сарын 02-ны өдрөөс эхлэн “Мэдээлэл холбооны сүлжээ” ТӨХК-ийн сүлжээнд шилжүүлсэн. Ингэснээр сүлжээний тасалдал багасч, хурд нь нэмэгдсэн.

2020 оны 2-р сарын 19-20-ны өдрүүдэд Булган сумын онлайн сүлжээ байнга тасалдаж муу ажиллагатай байсныг тогтоон, сүлжээний роутерийн портыг сольж хэвийн ажиллагааг хангасан.




Улаанхус, Алтанцөгц, Цагааннуур тосгоны сүлжээний роутерийн адаптер шатсан тул шинээр сольж өгсөн.

Тухайн сумын ЗДТГ-аас шинээр компьютер авч өгсөн Өлгий, Цэнгэл, Булган сумдын улсын бүртгэгч нарын офлайн програмын баазыг шинэ компьютерт нь хуулж, hardware id суулган сүлжээний тохиргоог шинэ компьютерт суурилуулж өгсөн.



Тус хэлтсийн дотоод сүлжээ буюу Улсын бүртгэлийн ерөнхий сүлжээ, интернетийн сүлжээг Microsoft Visio программ дээр дэлгэрэнгүй тополог зургийг гаргасан. Сүлжээний төхөөрөмжүүдийн ашиглалтын хугацаа, загвар, тоо ширхэгээр судалгааг шинээр гаргаж, тохиргоог хадгалж авсан болно.



5.2. Мэдээллийн аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд:

- 2020 оны 04-р сарын 14-ны өдөр аймгийн Тагнуулын газраас ирүүлсэн судалгааны дагуу хэлтсийн мэдээлэл технологийн талаарх асуултуудыг бөглөж хүргүүлэн ажилласан.

- Мэдээллийн болон кибер орчны аюулгүй байдлыг хангах Улаанбаатар хотоос ирсэн ажлын хэсэг болон аймгийн Тагнуулын газрын мэдээллийн аюулгүй байдлын урьдчилсан шалгалтад хамрагдсан.

- УБЕГ-аас боловсруулж буй “Цахим мэдээллийн санд мэдээлэл хүлээн авах, хадгалах, түүний аюулгүй байдлыг хангах журам”-ын төсөлтэй танилцаж саналаа хүргүүлсэн.

- Албан хаагчид мэдээллийн санд албан үүргийн дагуу өөр өөрсдийн эрхээр бүртгэлийн програм системд нэвтэрдэг. Ажлаас түр чөлөөлөгдсөн, гарсан, халагдсан, өөр ажилд шилжсэн албан хаагчийн эрхийг МТГ-т албан бичиг явуулж мэдээллийн санд нэвтрэх эрхийг цуцлуулж ажиллаж байна.

- Сумдын бүртгэгчид амаржсаны болон жирэмсэний амралт эдлэх, өндөр насны тэтгэвэрт гарах, урт хугацаагаар сургалтанд явахад тоног төхөөрөмжинд үзлэг хийж шалгаж авч, дараагийн бүртгэгчид хүлээлгэн өгч, хүлээлцсэн тухай тэмдэглэл хөтлөн ажиллаж байна.

- Улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн санд харьцаж ажиллаж байгаа албан хаагчдад ажлын хэрэгцээнд ашиглаж байгаа програм хангамжид хандан нэвтрэх нууц үгээ тодорхой хугацаанд буюу улиралд заавал сольж байх, нууц үгийн бүрдэл нь том, бага, үсэг, тоо, тусгай тэмдэгт хослуулсан байхыг зөвлөж ажиллаж байна.

- Албан хаагчдын компьютерийг вирусны эсрэг програмаар хангах хүсэлтийг МТГ-т тавьсан боловч одоогоор шийдвэрлэгдээгүй байна. Өөрийн компьютерт хувиасаа вирусны програм худалдан авч хэрэглэж байгаа ба гаднаас ирсэн флаш, дискийг уншуулан шалгаад албан хаагчдад шаардлагатай мэдээллийг хуулж өгдөг.

- Мэдээлэл алдахгүй байх аюулгүй байдлыг хангах зорилгоор компьютерт гадны зөөврийн диск, флэш оруулах портуудыг хааж, зөвхөн дундаа мэдээлэл солилцохоор дотоод сүлжээний Lan messenger, 100 нэгдсэн шэйрийг ашиглаж хэвшсэн.

- Албан хаагчдад тог тасарсан үед тог баригчаа унтраах, ажил тарсны дараа компьютерээ бүрэн унтраах бусад тоног төхөөрөмжүүдийг зөв, зохистой хэрэглэх талаар байнга зөвлөгөө өгч ажиллаж байна.

Байгууллагын аюулгүй байдлыг хангах үүднээс архивын өрөөнд 1 хяналтын камер нэмж суурилуулсан.

5.3. Хүний нөөцийн ажлын хүрээнд:

УБЕГ-ын даргын 2018 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн Б/07 тоот тушаалаар баталсан Улсын бүртгэлийн байгууллагын орон нутаг дахь салбар нэгжийн зохион байгуулалтын бүтэц, орон тоогоор 36 албан хаагчтайгаар үйл ажиллагаагаа явуулж байна. Үүнд: төрийн захиргааны албан хаагч 28, төрийн үйлчилгээний албан хаагч 5, гэрээт ажилтан 3 болно. Тус байгууллагад ажиллаж байгаа нийт албан хаагчдын 21 нь эмэгтэй буюу 58,3%, эрэгтэй 15 буюу 41,6%-ийг тус тус эзэлж байна.

Төрийн албаны зөвлөлөөс батлагдсан төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журмын дагуу албан хаагчдийн хувийн хэргийн баяжилт болон шинээр

томилогдсон албан хаагчдын хувийн хэргийг бичиг хэргийн ажилтанд хариуцуулан хийлгэж ЕГ-ын Хүний нөөц, сургалтын хэлтэст хүргүүлэн ажиллав.

Байгууллагын хүний нөөцийн бодлогын хүрээнд хүйсийн тэнцвэртэй байдлыг хангах бодлогыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

–“Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг ханган ажиллах хүрээнд:

–Хэлтсийн төрийн захиргааны албан хаагчдын төрийн алба хаасан хугацааны судалгааг гаргаж, цалингийн шатлал ахиулах шаардлагатай 20 албан хаагчийн цалингийн шатлал ахиулсан. Мөн зэрэг дэв шинээр олгох, ахиулах, албан хаагчдын судалгааг Төрийн албаны зөвлөлийн Улсын бүртгэлийн ерөнхий газрын дэргэдэх салбар зөвлөлд уламжлан шийдвэрлүүлсэн.

–Төрийн албаны зөвлөлийн Хүний нөөцийн нэгдсэн системд /hr.csc.gov.mn/ хэлтсийн албан хаагчдын үндсэн цалин болон сар бүр тогтмол авч буй нэмэгдлийг ахлах нягтлан бодогчоор хянуулан, мэдээллийг үнэн зөв оруулсан. Мөн хүний нөөцийн хөдөлгөөнтэй холбоотой өөрчлөлт, баяжуулалтыг тогтмол хийж байна.

–Ар гэрийн гачигдал, хүүхэд асрах болон хүндэтгэн үзэх шалтгааны улмаас чөлөө авахыг хүссэн албан хаагчдад чөлөө олгох ажлыг тухай бүр зохион байгуулж ажилласан.

–Шинээр хүүхэдтэй болсон 3 албан хаагчид Хөдөлмөрийн дотоод журмаар 100,000 төгрөг олгож, урамшуулав.

–Жендерийн тэгш байдлыг хангах үүднээс ажлын сул орон тоо гарсан буюу жирэмсний болон амаржсаны чөлөөтэй хугацаанд албан үүргийг түр орлон гүйцэтгэх 2 эмэгтэй албан хаагчийг ажилуулсан болно.

–COVID-19 өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хэлтсийн нийт албан хаагчдын халууныг тогтмол хэмжүүлэн ажиллаж байна.



5.4. Санхүү, аж ахуй, хангамж үйлчилгээний ажлын хүрээнд:

Хэлтсийн зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээг батлагдсан төсвийн хүрээнд хяналттай үр ашигтай, хэмнэлттэй байдлаар хэрэгжүүлж байна. 2020 оны эхний 11 сарын байдлаар улсын төсвөөс 451.523.900 төгрөгийн санхүүжилт авснаас 444.675.320 төгрөгийг зориулалтын дагуу зарцуулсан ба энэ нь нийт төсвийн 98.4% байна. Мөн тайлант хугацаанд 174.166.666 төгрөгийн орлогын төлөвлөгөөтэй байсанаас 165.517.824,97 төгрөгийн орлого оруулж, Сангийн Яам Улсын Төсөвт 165.081.824.97 төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн болно. Орлогын төлөвлөгөөг 95%-иар биелүүлсэн болно. Сар бүрийн 2-ны өдрийн дотор төсвийн

гүйцэтгэлийн тайлан ба өглөг авлага, нэр данс зөрүүгийн тайлан, санхүүгийн сарын мэдээг УБЕГ-т хүргүүлж ажиллаж байна. Үнэт цаасны зарцуулалтын тайлан болон үлдэгдлийн тайлан, иргэний үнэмлэхийн орлогын тайланг хугацаанд нь дээд газарт хүргүүлж байна. Одоогийн байдлаар тус хэлтэс нь ямар нэгэн өр авлагагүйгээр ажиллаж байгаа болно. Мөн түүнчилэн ХАОАТ болон НДШ-ийн тайлангуудыг хугацаанд нь гаргаж холбогдох байгууллагуудад хүргүүлсэн. Хэлтсийн 2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийлгүүлж “Зөрчилгүй” дүгнэлт авсан болно. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд холбогдох дансны мэдээллүүд болох тухай бүр оруулах 88 ш, сар бүр оруулах 33, улирал бүр оруулах 3, хагас жилээр оруулах 4, бүтэн жилээр оруулах 5 мэдээллүүдийг хуулинд заасан хугацаанд нь оруулж ажиллаж байна. Үнэт цаасны тооцоог сар болгон албан хаагч бүртэй хийж, үлдэгдэл үнэт цаасыг тулган ажилласан.

Хэлтсийн төсөв, санхүүгийн ил тод нээлттэй байдлыг хангах, байгууллага, иргэдэд нээлттэй байлгах ажлын хүрээнд байгууллагын мэдээллийн самбар болон цахим хуудаст 2020 оны төсөв болон орлого, зарлага, төсвийн байгууллагын санхүүжилтийн 1-11 дугаар сарын мэдээнүүдийг хуульд заасан хугацаанд шилэн дансанд байршуулсан. Мөн 2021 оны төсөв 2022-2024 оны төсвийн төсөөллийг хуулийн хугацаанд хүргүүлэн ажиллав. Санхүүгийн тайланг улирал, хагас жилээр гарган холбогдох газарт хүргүүлсэн. 11 сарын байдлаар Улсын Бүртгэлийн Ерөнхий Газраас 23.110.211 төгрөгийн үнэт цаас бараа материал, 3188746 төгрөгийн үндсэн хөрөнгийг хүлээн авч санхүүгийн тайландаа тусгасан болно.

5.5. Үйл ажиллагааг тайлагнах ажлын хүрээнд:

Улсын бүртгэлийн үйл ажиллагааг тайлагнах ажлын хүрээнд дараах тайлан мэдээг холбогдох байгууллагад хүргүүлэн ажиллав. Үүнд:

- Аймгийн Засаг дарга болон Засаг даргын зөвлөлд Улсын бүртгэлийн хэлтсийн 2019 оны үйл ажиллагааны тайланг танилцуулж, хэлтсийн даргын Засаг даргатай байгуулсан хамтран ажиллах гэрээ, төлөвлөгөөний биелэлтийг дүгнүүлэв. Цаашид бүртгэлийн үйл ажиллагааг улам сайжруулахад хамтран ажиллах талаар санал бодол солилцов.



- Иргэний бүртгэлийн тасгийн дарга Д.Аманбек иргэний бүртгэлийн хууль тогтоомж, түүний хэрэгжилтийн талаар аймгийн орон нутгийн радиод ярилцлага өгөв.



- Хяналтын улсын байцаагч А.Еркегүл Сонгуулийн тухай хуулийн 25.1-д заасны дагуу Иргэний засаг захиргааны нэг нэгжээс нөгөө нэгжид шилжин суурьших хөдөлгөөнийг 2020 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн санал авах өдрийн дараах өдрийг хүртэл түр зогсоохтой холбоотой болон бүртгэлийг хянан шалгах явцад гарч буй зөрчлийн талаар орон нутгийн телевизээр мэдээлэл хийв.
- Төрийн захиргааны албан хаагчийн 2019 оны ХАСХОМ-ын нэгдсэн тайлан,
- Хууль зүй, дотоод хэргийн дэргэдэх Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус зөвлөлийн ажлын хүрээнд УБЕГ-аас 2020 онд хийж, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хагас жил, бүтэн жилийн биелэлт,
- Аймгийн засаг даргатай 2019 онд хамтран ажиллахаар байгуулсан гэрээний биелэлт,
- Улсын бүртгэлийн үйлчилгээний талаарх сар бүрийн тоон мэдээг УБЕГ-т хүргүүлж ба хэлтсийн цахим хуудасны тоон мэдээ цонхонд тогтмол байршуулан ажиллаж байна.

5.6. Албан хэрэг хөтлөлт, өргөдөл, гомдол шийдвэрлэх ажлын хүрээнд:

Хэлтсийн үйл ажиллагаа, авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар санал, гомдол, хүсэлт хүлээн авах хайрцаг ажиллуулж ирсэн ба санал хүсэлт, мэдээллийг төрөлжүүлэн дүгнэж, тэдгээрийн мөрөөр авах арга хэмжээг зохион байгуулж байна. Өдөр тутмын үйл ажиллагаа болон улсын бүртгэлийн бүртгэгчдийн үйлчилгээ, зан харилцааны асуудлаарх иргэдийн өргөдөл, гомдол санал хүсэлтийг тухай бүр хэлтсийн дарга биечлэн хүлээн авч шийдвэрлэн, иргэдэд ойлгомжгүй байгаа асуудлыг Тасгийн дарга нараар тайлбарлуулан иргэдэд үйлчилж байна.

Авлига, ашиг сонирхол зөрчлийн талаар мэдээлэл ирээгүй байна.

Тайлангийн хугацаанд /2020.12.15-ны өдрийн байдлаар/ хууль хяналтын болон бусад байгууллагуудаас 1491 албан бичиг хүлээн авсан байх ба нийтдээ 1710 албан бичиг гадагш явуулсны 1113 нь хууль, хяналтын байгууллага болон бусад байгууллагад хүргүүлсэн хариутай албан бичиг болно.

Мөн хэлтсийн даргын 36 тушаалыг гарган холбогдох арга хэмжээг авч ажилласан байна.

Оны эхнээс /2020.12.15/ иргэдээс нийт 245 өргөдөл хүлээн авч, Хэлтсийн даргад танилцуулан холбогдох албан хаагчдад цохилт хийлгэж, хугацаанд нь шийдвэрлүүлсэн. Үүнээс: Захиргаа удирдлагад 7 өргөдөл, Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн чиглэлээр 8, Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр 14 өргөдөл ирсэн байх ба Иргэний бүртгэл болон Хяналтын улсын байцаагчийн дүгнэлт гаргахтай холбоотой /үрчлэлт, төрөлт, нас баралт, гэрлэлт, гэрлэлт дуусгавар болсоныг бүртгүүлэх мөн регистрийн дугаар зөвөтгөх, гэрчилгээ дахин олгох, тодорхойлолт, лавлагаа олгохдоо холбоотой 216 байна.


2020 оны 12 сарын 15-ны байдлаар нийт 245 иргэний өргөдлөөс 237 өргөдлийг шийдвэрлэж, бусад байгууллагад шилжүүлсэн 0, хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн 0, хугацаа болоогүй 8 иргэний өргөдөл хяналтад байна. Мөн шийдвэрлэлтийн хувь 96.73%-тай байна.

Иргэдийн ирүүлсэн өргөдөл, гомдлыг ангилвал иргэний бүртгэлийн чиглэлээр иргэний баримт бичгийн зөрчилтэй холбоотой өргөдөл гомдол ихэнх хувийг эзэлж байгаа ба иргэдийн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд нь шийдвэрлэж байгаа болно. Мөн иргэдийн өргөдөл, гомдлыг Хэлтсийн 70427810, 70427766 дугаарын утсаар авч ажиллаж байна.

Өргөдөл гомдлын мэдээг загвар хүснэгт дагуу гаргаж, улирлын сүүлийн сарын 15-ны дотор УБЕГ-ын Тамгын газрын өргөдөл, гомдол хариуцсан мэргэжилтэнд баталгаажуулан хүргүүлж байна.

Мөн хэлтсийн цахим хуудасны өргөдөл, гомдлын цонхонд тогтмол байршуулж байгаа болно.

Ажилчдын ажлын цаг ашиглалтыг сайжруулах талаарх албан даалгаврыг ажилтнууддаа танилцуулан, хэлтсийн ажилтнуудын цагийн бүртгэлд тавих хяналтыг сайжруулан, өглөө болгон цагийн бүртгэлтэй танилцаж, чиглэл өгч ажилласан. Сумдын анхан шатны бүртгэгчдийн цаг ашиглалтын байдалд сумын Засаг даргын тамгын газартай хамтран хяналт тавин ажиллаж байна.



5.7. Сургалт, сурталчилгаа, ил тод нээлттэй байдал

–Тайлант хугацаанд УБЕГ-аас болон хэлтсийн хэмжээнд зохион байгуулагдсан нийт 34 удаагийн танхимын болон онлайн сургалтын бэлтгэл ажлыг ханган ажилласан. Давхардсан тоогоор 664 хүн хамрагдав.

Д/д	Он, сар, өдөр	Хаанаас зохион байгуулсан	Хэлбэр	Сургалтын агуулга	Хамрагдсан тоо	Тайлбар
1	2	3	4	5	6	7
1	2020.01.03	УБХ, ИБТ	Онлайн	Шилжилт хөдөлгөөнтэй холбоотой	15	Сумдын улсын бүртгэгч нар хамрагдав
2	2020.01.04	УБЕГ, ХЭБГ	Онлайн	Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн бүртгэлийн тухай	1	Улсын бүртгэгч хамрагдав
3	2020.01.17	УБЕГ, БТДШГ	Онлайн	2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулахад анхаарах асуудлаар мэдээлэл өгөх" сургалт	1	Хэлтсийн дарга хамрагдав
4	2020.02.07	УБЕГ, БТДШГ	Онлайн	2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулахад анхаарах асуудлаар мэдээлэл өгөх" сургалт	27	Хэлтсийн төрийн захиргааны албан хаагчид хамрагдав.
5	2020.02.11	Нийгмийн даатгалын хэлтэс	Танхим	Нийгмийн даатгалын тухай хуулийн талаар ойлголт	20	Хэлтсийн төвийн албан хаагчид хамрагдав.
6	2020.02.14	УБХэлтсийн дарга	Танхим	Байгууллагын уур амьсгал, харилцааны талаар хичээл оров	20	Хэлтсийн төвийн албан хаагчид хамрагдав
7	2020.03.06	УБЕГ, ИУБГ	Онлайн	Сонгогчийн нэрийн жагсаалт хэвлэх, хэсэг оноох	6	Хэлтсийн дарга, ХУБ, ИУБТасгийн (төвийн) албан хаагчид хамрагдав.
8	2020.03.09	Хууль зүйн туслалцааны дарга Т.Костёр	Танхим	Хамт олны уур, амьсгал, харилцааны соёл	20	Төвийн албан хаагчид
9	2020.03.23	УБХ, ЭХЭУБТ,	Танхим	Улсын бүртгэгчийн эрх үүрэг	16	Төвийн улсын бүртгэгчид
10	2020.03.23	УБХэлтсийн дарга	Танхим	Улсын бүртгэлийн байгууллагын нууц хамгаалах журам, албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалт	21	Хэлтсийн төвийн албан хаагчид хамрагдав
11	2020.03.23	УБЕГ, ЭХЭУБГ	Онлайн	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөхөд гарч буй нийтлэг алдаа, цахим систем боловсруулахад анхаарах асуудал	6	Хэлтсийн дарга, ХУБ, ЭХЭУБ тасаг

12	2020.03.24	УБХэлтсийн дарга, УБүртгэгч	Онлайн	Улсын бүртгэлийн байгууллагын нууц хамгаалах журам, албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалт, Улсын бүртгэгчийн эрх үүргийн талаар	14	Сумдын улсын бүртгэгч нар хамрагдав
13	2020.04.15 -04.16	УБЕГ	Онлайн	Удирдах ажилтны сургалт	5	Хэлтсийн дарга, ИУБ, ЭХЭУБ-ийн тасгийн дарга, ХЭБ, Нягтлан, МТА
14	2020.04.17	УБЕГ, ТГ	Онлайн	Бичиг хэргийн ажилтны сургалт	1	Бичиг хэргийн ажилтан
15	2020.04.17	УБЕГ, ИУБГ	Онлайн	Иргэний улсын бүртгэлийн системийн сонгуулийн модулийн танилцуулга	5	ИУБ тасаг
16	2020.04.23	УБЕГ, ИУБГ	Онлайн	Иргэний улсын бүртгэлийн шинэ системийн туршилт	5	ИУБ тасаг
17	2020.04.30	УБЕГ, ХЭБГ	Онлайн	Хуулийн этгээдтэй холбоотой хууль, журмын хэрэгжилт, анхаарах асуудал	1	Улсын бүртгэгч хамрагдав
18	2020.05.06	УБЕГ, ХШГ	Онлайн	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл чиглэлээр боловсруулсан хяналтын улсын байцаагчийн дүгнэлт	1	ХУБ хамрагдав
19	2020.05.07	УБЕГ, ХШГ	Онлайн	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр боловсруулсан хяналтын улсын байцаагчийн дүгнэлт	1	ХУБ хамрагдав
20	2020.05.08	УБЕГ, ХШГ	Онлайн	Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр боловсруулсан хяналтын улсын байцаагчийн дүгнэлт	1	ХУБ хамрагдав
21	2020.05.13	УБЕГ, ХШГ	Онлайн	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл чиглэлээр боловсруулсан хяналтын улсын байцаагчийн дүгнэлт	1	ХУБ хамрагдав
22	2020.05.14	УБЕГ, ХШГ	Онлайн	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр боловсруулсан хяналтын улсын байцаагчийн дүгнэлт	1	ХУБ хамрагдав
23	2020.05.15	УБЕГ, ХШГ	Онлайн	Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр боловсруулсан хяналтын улсын байцаагчийн дүгнэлт	1	ХУБ хамрагдав
24	2020.05.21	УБХ	Онлайн	Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуульд ажиллах улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтнуудад зориулсан эрх зүйн сургалт	108	Итгэмжлэгдсэн ажилтнууд хамрагдав

25	2020.05.26	УБЕГ, ТГ	Онлайн	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалт	6	Хэлтсийн дарга, ХУБ, ИУБ, ЭХЭУБ-ийн тасгийн нар, ХЭУБ, ИУБ нар хамрагдав
26	2020.05.27	УБЕГ, ТГ	Онлайн	Хүүхдийн эрх, Аюулгүй байдлыг хангах тухай	5	Хэлтсийн дарга, ХУБ, ИУБ, ЭХЭУБ-ийн тасгийн нар, МТА хамрагдав.
27	2020.06.12 -06.13	УБЕГ-ын сургалтын баг, УБХ	Танхим	Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуульд ажиллах улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтнуудад зориулсан ирц бүртгэлийн программын сургалт	108	Итгэмжлэгдсэн ажилтнууд хамрагдав
28	2020.08.07	УБЕГ-ын дарга Д.Дэлгэрсайхан	Онлайн	Улсын бүртгэлийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой	1	Хэлтсийн дарга хамрагдав
29	2020.08.11	УБЕГ, ХШГ, ЭХЭУБ	Онлайн	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үрэгдүүлсэн, гэмтээсэн гэрчилгээг хүчингүйд тооцох тухай	3	Хэлтсийн дарга, ХУБ, ЭХЭУБТ дарга нар хамрагдав
30	2020.09.15	УБХ	Онлайн	АНСДИТХ-ын сонгуульд ажиллах улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтнуудад зориулсан эрх зүйн сургалт	96	Итгэмжлэгдсэн ажилтнууд хамрагдав
31	2020.10.03	УБЕГ-ын сургалтын баг, УБХ	Танхим	АНСДИТХ-ын сонгуульд ажиллах улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтнуудад зориулсан эрх зүй, ирц бүртгэлийн программын сургалт	96	Итгэмжлэгдсэн ажилтнууд хамрагдав
32	2020.10.23	УБХ ИБТ-ийн дарга, МТА	Онлайн	Нэмэлт санал хураалт явуулах хэсгийн ИА-нуудад зориулсан сургалт	6	Итгэмжлэгдсэн ажилтнууд хамрагдав
33	2020.11.11	УБХ Хэлтсийн дарга	Онлайн	Бүртгэлийн үйл ажиллагаа, анхаарах асуудал	15	Сумдын улсын бүртгэгч нар хамрагдав
34	2020.11.30	УБХ Хяналтын улсын байцаагч ХЭУБ	Онлайн	Төрийн албан хаагч нарыг зөрчил, гэмт хэргээс урьдчилан сэргийлье сэдэвт сургалт	30	Хэлтсийн албан хаагчид оролцов
Нийт хамрагдсан албан хаагчдын тоо:					664	

2020 оны 2-р сарын 04-ны өдөр сумдын Засаг дара нарын сургалтанд оролцож, Улсын бүртгэлийн байгууллагын үйл ажиллагаанд сумдын удирдлагын оролцоо сэдэвт мэдээлэл хийж, санал солилцов.




2020 оны 2-р сарын 14-ны өдөр хэлтсийн дарга С.Арман хэлтсийн албан хаагчдад Байгууллагын уур амьсгал, харилцааны талаар хичээл орлоо.



2020 оны 3-р сарын 23-ны өдөр хэлтсийн дарга С.Арман Улсын бүртгэлийн байгууллагын нууц хамгаалах журам, албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалт, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч К.Ерке Улсын бүртгэгчийн эрх, үүргийн талаар хичээл орлоо. Сургалтад сумдын улсын бүртгэгч нарт онлайнаар холбогдов.

2020 оны 05-р сарын 21-ний өдөр Баян-Өлгий аймгийн Улсын бүртгэлийн хэлтсээс Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуульд ажиллах улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтнуудад цахим сургалт хийлээ. Сургалтад тус аймгийн 96 хэсэгт ажиллах 108 итгэмжлэгдсэн ажилтан хамрагдав.



Сургалтын үеэр зохион байгуулагч болон Тагнуулын газраас итгэмжлэгдсэн ажилтны чиг үүрэг, гүйцэтгэх ажил, УИХ-ын сонгуулийн тухай хууль, төрийн албан хаагчийн ёс зүй, төрийн нууцын хадгалалт, хамгаалалт, мэдээллийн сангийн аюулгүй байдлыг хангах, иргэний улсын бүртгэл ба сонгогчийн бүртгэл, нэрсийн жагсаалт үйлдэх, сонгогч шилжих журам зэрэг сэдвээр мэдээлэл өглөө.



2020 оны 06-р сарын 12-13-ны өдрүүдэд Монгол Улсын Их Хурлын сонгуулиар ажиллах улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтнуудын ирц бүртгэлийн программын сургалтыг зохион байгуулав. Сургалтын багийн ахлагчаар УБЕГ-ын ХШГ-ын дарга Б.Ганзориг, гишүүнээр ИУБГ-ын улсын бүртгэгч Ч.Батцэцэг, МТГ-ын инженер Э.Төртогтох нар оролцов.

Сургалтын үеэр итгэмжлэгдсэн ажилтнуудын халууныг хэмжиж, амны хаалт, гар ариутгагч тараан онцгой байдлын дэг журмыг чанд сахин ажилласан болно.



2020 онд биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлд шинээр хамрагдах иргэдэд анхааруулах зорилгоор анонс хийж байгууллагын сошиал хуудсаар болон цахим хуудсаар түгээж ажиллав.

Сонгуулийн тухай хуулийн 25.1-д заасны дагуу Иргэний засаг захиргааны нэг нэгжээс нөгөө нэгжид шилжин суурьших хөдөлгөөнийг 2020 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн санал авах өдрийн дараах өдрийг хүртэл түр зогсоохтой холбоотой мэдээллийг цахим хуудсаар дамжуулан сурталчилан ажиллав.





Монгол Улсад коронавируст халдвар /COVID-19/ бүртгэгдэж, улсын хэмжээнд өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэнтэй холбогдуулан Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2020.03.13-ны өдрийн

A/259, A/554 дүгээр тушаалаар ажлын тусгай горимд шилжиж тушаалын хэрэгжилтийг ханган ажиллав. Иргэдэд үйлчилгээ үзүүлэх цагийн хуваарийн талаар цахим хуудас, байгууллагын мэдээллийн самбарт тогтмол байршуулан ажиллав.

COVID-19 өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор ИРГЭН ТА бүртгэлийн үйлчилгээтэй холбоотой мэдээллийг заавал өөрийн биеэр ирэхгүйгээр доорх НЭЭЛТТЭЙ УТАС болон ЦАХИМ хуудсаар дамжуулан авах боломжтой анонс хийж байгууллагын сошиал хуудсаар болон цахим хуудсаар түгээж ажиллав.
<https://bayan-ulgii.burtgel.gov.mn/post/56094> <http://www.facebook.com/ubh.bo.gov.mn>

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4-т заасны дагуу сонгогчдын нэрийн жагсаалтыг <http://election.burtgel.gov.mn/> цахим хуудсанд байршуулсан. Үүнтэй холбогдуулан Сонгогч та <http://election.burtgel.gov.mn/> холбоосоор орж өөрийн бүртгэлийг баталгаажуулна уу баннерийг хэлтсийн цахим хуудсанд байршуулан олон нийтэд түгээж ажилласан ба үйлчилгээний зааланд компьютер байршуулан угтах үйлчилгээний ажилтнаар үйлчлэгчдийн мэдээллийг шалгуулан баталгаажуулалт хийлгэн ажиллаж байна.




Монгол Улсын иргэний үнэмлэхийн бүртгэлтэй холбоотой түгээмэл асуулт, хариулт нийтлэлийг хэлтсийн цахим хуудсанд байршуулан олон нийтэд түгээж ажилласан. http://ubh.bo.gov.mn/index.php?option=com_content&view=article&id=1644:irgeni-unemleh

www.burtgel.mn цахим хуудас болон иргэд цахим үнэмлэхээ онлайнаар захиалах боломжтой болсон талаар мөн шинэ хуулийн брошур, гарын авлагыг хэлтсийн цахим хуудас болон фэйсбук фэйжээр олон нийтэд сурталчилан ажиллав.

Бүртгэлийн нэгжийн статистик тоон мэдээгээр брошур хэвлэж аймгийн холбогдох төрийн байгууллагуудад, нээлттэй хаалганы өдөрлөгөөр иргэдэд тарааж, цахим хуудаст байршуулан харилцан мэдээлэл солилцож ажиллаж байна.

"Амны хаалтаа зүүцгээе" аянд нэгдэж видео шторк хийж хэлтсийн цахим хуудсанд байршуулан олон нийтэд түгээж ажилласан. <https://youtu.be/VvE8l7Nvgno>
<https://www.facebook.com/ubh.bo.gov.mn/videos/238727433879473/>



Ковид-19 цар тахлын үеэр аймгийн онцгой комистой хамтран Улаанбаатар хотоос ирсэн зорчигчдыг бүртгэх, шуурхай штабт 24 цагаар жижүүрт гарах болон хэлтэс дээр 2020 оны 11-р сарын 11-ээс эхлэн тогтмол хариуцлагатай жижүүрүүд ажиллаж ба иргэн, хуулийн этгээдэд утсаар мэдээлэл өгч ажилласан.



5.8. Мэдээллийн ил тод байдал, цахим хуудаст мэдээлэл байршуулах ажлын хүрээнд:

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, ЗГ-ын 2013 оны 411 дүгээр тогтоолоор батлагдсан “Мэдээллийн ил тод байдлыг хангах нийтлэг журам”, Хууль зүйн сайдын 2012 оны А/15 дугаар тушаалаар батлагдсан “Хууль зүйн салбарын Нээлттэй бодлогын баримт бичиг”, Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлтээр тогтоосон ил тод нээлттэй байдлыг мэдээллийн цахим хуудсанд бүрэн байршуулж, олон нийтийг мэдээллээр ханган ажиллаж байна.

Тус хэлтсийн цахим хуудас нь <http://www.ubh.bo.gov.mn> хаягтай байсан ба 2020 оны 11-р сарын 01-нээс УБЕГ-аас нэгдсэн нэг загварын <https://bayan-ulgii.burtgel.gov.mn/> гэсэн хаягтай шинэ цахим хуудастай болсон.

Улсын бүртгэлийн хэлтсийн үйл ажиллагааг олон нийтэд түгээх зорилгоор хийсэн ажлын талаарх мэдээллийг фото зургийн хамт цахим хуудаст болон олон нийтийн сошиал сүлжээ буюу <https://www.facebook.com/ubh.bo.gov.mn/> фэйсбук пэйж хуудсаар давхар түгээж ажиллаж байна. Үүнээс гадна УБЕГ-аас гаргасан аливаа шторк, мэдээллүүд, цахимаар бүртгэлийн үйлчилгээ авах зэрэг мэдээллийг тухай бүр байршуулан шэйр хийж байна. Өнөөдрийн байдлаар 2155 дагагчтай болсон байна. 2020 онд сошиал хуудсаар дамжуулан 25 иргэн мессэж илгээж бүртгэлийн талаар мэдээлэл авсан байна.


далбаа, газрын зургийг бүрэн оруулсан. Баннер хэсэгт иргэн, хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн лавлагаа, үйлчилгээ авах цахим систем, хуулийн этгээдийн оноосон нэр олголтын систем, авлигыг мэдээлэх 110 утас болон бүртгэлийн нэгдсэн лавлах 1800-1890 зэрэг баннерүүдийг байршуулсан.

Цахим хуудасны хөл хэсэгт бусад аймгуудын холбоос болон хэлтсийн Google map дахь газрын зургийг харуулсан болно.

Фэйсбук пейж хуудасанд цахим хуудасны холбоос, утасны дугаар, цахим шуудан хаяг, цагийн хуваарийг шинэчлэн оруулсан ба cover зурганд байгууллагын гадна талын зураг байршуулан баруун талд нь ажиллах цагийн хуваарь, нээлттэй утаснуудыг бичсэн.

5.7. Олон нийтийн ажлын хүрээнд

Шинэ төрлийн коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор албан хаагчид ашиглаж буй техник хэрэгсэл болон албаны өрөөнд ариутгалын бодисоор цэвэрлэгээ хийв. Мөн өрхийн эмнэлгийн эрүүл мэндийн ажилтнаар албан хаагчдын халууныг үзүүлэн ажиллаж байна.



Ковид-19 вирусын халдвараас урьдчилан сэргийлэх онцгой нөхцөл байдал үүсч, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг 2020 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаагаар хойшлуулах шийдвэр гарсантай холбогдуулан гэртээ байгаа хүүхэд багачуудын цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх, авьяас чадвараа хөгжүүлэх, нийгэмд оролцох эрхийг хангахад зорилгоор 2020 оны 4-р сарын 20-ноос 05-р сарын 20-ны өдрийн хооронд тус хэлтсийн эцэг эхийн зөвлөлөөс албан хаагчдын 12 хүртэлх насны хүүхдүүдийн дунд “Миний мөрөөдөл” сэдэвт гар зургийн цахим уралдаан зохион байгуулав.



2020 оны 04 дүгээр сарын 21-ны өдөр, 10 дугаар сарын 05-ны Өлгий хотоос гарах чиглэлийн хуваарьт газарт 2 удаа, 11-р сарын 03-ны өдөр байгууллага орчимд их цэвэрлэгээ хийв.



5.8. Аймгийн төрийн болон төрийн бүс байгууллагуудтай хамтын ажиллагаа, уулзалтын талаар

Аймгийн ЗДТГ, болон бусад төрийн байгууллагатай хамтран ажиллаж, холбогдох тайлан мэдээг хүргүүлэн ажилласан ба төрийн болон хууль хяналтын байгууллагад лавлагаа мэдээллийг хүргүүлэн ажиллаж байна.

Баян-Өлгий аймаг дахь Цагдаагийн газраас залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор улсын хэмжээнд зохион байгуулж байгаа "ЯТГАХ ТУСАМ НЯГТАЛ" аянд тус хэлтсийн албан хаагчид нэгдлээ.



Аймгийн Хууль зүйн туслалцааны төвийн дарга, ахмад хуульч Т.Костёрийг хэлтэс дээр урьж, “Хамт олны уур, амьсгал, харилцааны соёл” сэдэвт хичээл заалгав.



Шинэ төрлийн Корона вирус буюу /COVID-19/-ээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд тус хэлтсийн хамтран ажилладаг Баян-Өлгий аймаг дахь Улаан загалмайн хорооноос албан хаагчдад гар ариутгагчийн бодис Санитол, маск тарааж өгөв.



Аймгийн Нийгмийн даатгалын хэлтсээс тус хэлтсийн албан хаагчдад Нийгмийн даатгалын тухай хуулийн талаар мэдээлэл өгч, Улсын бүртгэл дэх үрчлэлтийн болон овог нэр, өөрийн нэр өөрчлөлтийн бүртгэл хөтлөхөд анхаарах асуудлын талаар хамтран ажиллах санал солилцов.



2020 оны 2-р сарын 28-ны өдөр Газрын харилцаа, хот байгуулалтын газрын удирдлагууд болон газрын даамалуудыг хэлтэс дээр урьж хамтарсан уулзалт зохион байгууллаа. Уулзалтанд дундын мэдээллийн сангаас дугаар олголт, газар эзэмших эрхийн бүртгэлтэй холбоотой санал солилцож, хамтран ажиллахаар тохиролцов.



Төрийн аудитын байгууллагаар тус хэлтсийн 2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийгдэж "ЗӨРЧИЛГҮЙ" дүгнэлт авав.

Дэлхийн олон улс, оронд хурдацтай тархаж буй Коронавирусийн /COVID-19/ халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг дэмжиж Улсын бүртгэлийн хэлтсийн албан хаагчид нийгмийн хариуцлагаа ухамсарлан Аймгийн онцгой комисст 700,000 төгрөгийн сэтгэлийн хандив өргөлөө.



2020 оны 04-р сарын 03-ны өдөр Аймгийн Засаг дарга А.Гылымхан, ЗДТГ-ын Хууль зүйн хэлтсийн дарга Ө.Хуралай нар Улсын бүртгэлийн хэлтсийн үйл ажиллагаатай танилцаж, төрийн үйлчилгээг ард иргэдэд түргэн шуурхай хүргэх талаар санал солилцож, архивын өрөө нь цаашид багтаамжгүй болсныг онцлон тус хэлтсийг шинээр баригдаж буй Төрийн үйлчилгээний цогцолборт оруулан байраар хангахаа мэдэгдлээ.

5.9. Улсын бүртгэлийн байгууллага үүсэж хөгжсөний 80 жилийн ойн хүрээнд

Улсын бүртгэлийн байгууллага үүсэж хөгжсөний 80 жилийн ойг тохиолдуулан Баян-Өлгий аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсээс “ВОЛЕЙБОЛ”-ийн тэмцээнийг амжилттай зохион байгууллаа.

Тус тэмцээнд хамтран ажилладаг байгууллагууд болох ГХБХБГазар, Нийгмийн даатгалын хэлтэс, Татварын хэлтэс болон арилжааны банкуудын баг тамирчид оролцож, авхаалж самбаагаа сорьж хүчтэй өрсөлдлөө.

Нийт багуудад халуун баяр хүргэж, цаашдын ажилд нь амжилт бүхний дээдийг хүсэн ерөөе!



2020 оны 10-р сарын 28, 29-ны өдрүүдэд Улсын бүртгэлийн байгууллагын үүсэж хөгжсөний 80 жилийн ойг тохиолдуулан аймгийн Толбо, Дэлүүн сумдад “НЭЭЛТТЭЙ ХААЛГА”-ны өдөрлөг зохион байгуулав.

Өдөрлөгийг хэлтсийн дарга үг хэлж нээж, Улсын бүртгэлийн байгууллагын үйл ажиллагаа, шинээр нэвтрүүлсэн цахим үйлчилгээний талаар, Хяналтын улсын байцаагч хугацаатай бүртгэл, хугацаа хэтэрсэн тохиолдолд хэрхэн шийдвэрлэх, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар мэдээлэл хийж улсын бүртгэгч нар газар дээр нь бүртгэлийн үйлчилгээ үзүүлэв.

Нээлтийн арга хэмжээний хуралд Толбо суманд 130 иргэн, Дэлүүн суманд 110 иргэн хамрагдсанаас хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн нөхөн бүртгэл 29, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл 77, гадаад паспортын захиалга 6, иргэний улсын бүртгэлийн 80 иргэнд үйлчилгээ үзүүлсэн ба хөгжлийн бэрхшээлтэй, амьдралын хүнд нөхцөл байдалтай 53 иргэнийг хуулийн дагуу тэмдэгтийн хураамж, торгуулиас чөлөөлж бүртгэлд хамруулав.

Мөн шинээр гэр бүл болсон иргэдийн гэрлэлтийг улсын бүртгэлд бүртгэж, гэрлэсний баталгааг ёслол төгөлдөр гардуулав.

Цаашид ойн арга хэмжээг утган “НЭЭЛТТЭЙ ХААЛГА”-ны өдөрлөгийг Алтай, Алтанцөгц, Баяннуур, Буянт, Өлгий сумдад зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.



2020 оны 11-р сарын 02, 03-ны өдрүүдэд Улсын бүртгэлийн байгууллагын үүсэж хөгжсөний 80 жилийн ойг тохиолдуулан аймгийн Буянт, Алтай сумдад “НЭЭЛТТЭЙ ХААЛГА”-ны өдөрлөг зохион байгуулав.

Өдөрлөгийн үеэр улсын бүртгэлийн байгууллагын үйл ажиллагаа, шинээр нэвтрүүлсэн цахим үйлчилгээ, бүртгэлд хугацаанд нь хамрагдах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар мэдээлэл өгч, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл, хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн нөхөн бүртгэлийн үйлчилгээг газар дээр нь хүргэн ажиллав.

Нээлтийн арга хэмжээний хуралд Буянт суманд 75 иргэн, Алтай суманд 70 иргэн хамрагдав. Эрх зүйн чадамжгүй, хөгжлийн бэрхшээлтэй, цэргийн алба хааж ирсэн иргэдийг хуулийн дагуу торгуулиас чөлөөлж бүртгэлд хамруулав.

Мөн шинээр гэр бүл болсон иргэдийн гэрлэлтийг улсын бүртгэлд бүртгэж, гэрлэсний баталгааг ёслол төгөлдөр гардуулав.



2020 оны 11-р сарын 05, 06-ны өдрүүдэд Улсын бүртгэлийн байгууллагын үүсэж хөгжсөний 80 жилийн ойг тохиолдуулан аймгийн Алтанцөгц, Баяннуур сумдад “НЭЭЛТТЭЙ ХААЛГА”-ны өдөрлөг зохион байгуулав. Уг өдөрлөгт хэлтсийн дарга, хяналтын улсын байцаагч, хуулийн этгээдийн улсын бүртгэгч, иргэний улсын бүртгэгч, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч нарын 6 хүний бүрэлдэхүүнтэй ажилласан.

Өдөрлөгийг хэлтсийн дарга үг хэлснээр нээж, Улсын бүртгэлийн байгууллагын үйл ажиллагаа, шинээр нэвтрүүлсэн цахим үйлчилгээ, хугацаатай бүртгэл, хугацаа хэтэрсэн тохиолдолд хэрхэн шийдвэрлэх, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийг нөхөн бүртгүүлэх талаар мэдээлэл өгч, улсын бүртгэгч нар ажлын 8 цагт газар дээр нь иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн бүртгэлийн үйлчилгээг үзүүлэв.

Нээлтийн арга хэмжээний хуралд Алтанцөгц суманд давхардсан тоогоор 70 иргэн, Баяннуур суманд 80 иргэн хамрагдав. Алслагдмал сумдыг зорьж, газар дээр нь ирж үйлчилгээ үзүүлсэнийг ард иргэд сайшааж, ажлын амжилт хүсэн талархал илэрхийлэв.



Улсын бүртгэлийн байгууллагын үүсэж хөгжсөний 80 жилийн ойг тохиолдуулан Өлгий сумын иргэний танхимд “НЭЭЛТТЭЙ ХААЛГА”-ны өдөрлөг зохион байгуулав.

Өдөрлөгт хэлтсийн дарга Т.Заманбек, Хяналтын улсын байцаагч А.Еркегүл, Хуулийн этгээдийн улсын бүртгэгч С.Арман, Мэдээллийн технологийн ажилтан Т.Батырхан, Өлгий сум хариуцсан улсын бүртгэгч О.Алтанцэцэг, М.Роза нар оролцлоо.

Улсын бүртгэлийн байгууллагын үйл ажиллагаа, шинээр нэвтрүүлсэн цахим үйлчилгээ, хугацаатай бүртгэл, хугацаа хэтэрсэн тохиолдолд хэрхэн шийдвэрлэх, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийг нөхөн бүртгүүлэх талаар мэдээлэл хийж улсын бүртгэгч нар газар дээр нь бүртгэлийн үйлчилгээ үзүүлэв.

Өдөрлөгийн арга хэмжээнд 102 иргэн оролцож, 71 иргэнд бүртгэлийн үйлчилгээ үзүүлснээс хөгжлийн бэрхшээлтэй, амьдралын хүнд нөхцөл байдалтай иргэнийг хуулийн дагуу тэмдэгтийн хураамж, торгуулиас чөлөөлж бүртгэлд хамруулав. 2020 оны төрсний бүртгэлийн 999,1000 дахь дугаарт бүртгүүлсэн шинээр төрсөн хүүхдийн төрсний гэрчилгээ, шинээр гэр бүл болсон хосуудын гэрлэлтийн гэрчилгээ, иргэний бичиг баримтгүй байсан Өлгий сумын 4-р багийн иргэн Д.Эрдэнэчимэгийг бичиг баримтжуулан ёслол төгөлдөр гардуулж өгөв.

Энэхүү зохион байгуулсан “НЭЭЛТТЭЙ ХААЛГА”-ны өдөрлөгийг Өлгий сумын ЗДТГ болон оролцсон иргэд сайшаан, ажлын амжилт хүсэж, баярлаж талархсанаа илэрхийлэв.



Улсын бүртгэлийн хэлтсийн хамт олон бүртгэлийн байгууллага үүсэж хөгжсөний 80 жилийн ойн баярын хүрээнд аймгийн онцгой комисст хандив өргөлөө.

Монгол улсын Засгийн газар, Улсын Онцгой комиссын шийдвэрээр бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжиж, Улаанбаатар хот, зарим аймгуудад /Covid-19/ халдварт өвчний батлагдсан тохиолдол бүртгэгдсээр байна.

Үүнтэй холбогдуулан аймгийн Засаг дарга, Онцгой Комиссын даргын Уриалгыг дэмжиж Улсын бүртгэлийн байгууллагын 80 жилийн ойн өдөр буюу өнөөдөр Баян-Өлгий аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн албан хаагчид үүрэг хариуцлагаа өндөржүүлж, нийгмийн хариуцлагаа ухамсарлан, халдварт өвчтэй тэмцэх, хүнд нөхцөлд үүрэг гүйцэтгэн ажиллаж буй төрийн албан хаагч нарынхаа эрүүл мэндийг дэмжих зорилгоор Аймгийн онцгой комисст 500,000 төгрөг, 200 ширхэг амны хаалт хандивлалаа.

Засаг дарга бөгөөд Онцгой Комиссын даргын Уриалгыг дэмжиж Эх орон, элгэн садан, хайртай бүхнийхээ эрүүл энхийн төлөө, нийгмийн хариуцлагаа ухамсарлаж төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүдийг нэгдэхийг УРИАЛЖ байна.



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС